



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2022 он

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНДЭЗНК	Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БНАКУ	Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс
БНӨСУ	Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хант Улс
Ковид-19	Коронавируст халдвар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗХАХБ	Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

АГУУЛГА

1.1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ	6
<i>Эдийн засгийн өсөлт</i>	6
<i>Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл</i>	7
<i>Инфляц</i>	8
<i>Ажил эрхлэлт, ажилгүйдэл</i>	9
1.2. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ	11
<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр</i>	11
<i>Уул уурхай, хүнд үйлдвэр</i>	13
<i>Эрчим хүч</i>	15
<i>Зам, тээвэр</i>	16
<i>Барилга, хот байгуулалт</i>	19
<i>Аялал жуулчлал</i>	21
<i>Харилцаа холбоо</i>	21
1.3. ХҮНИЙ ХӨГЖИЛ	23
<i>Эрүүл мэнд</i>	24
<i>Боловсрол</i>	25
<i>Шинжлэх ухаан, технологи</i>	27
<i>Нийгмийн хамгаалал</i>	29
<i>Хөдөлмөр эрхлэлт</i>	30
<i>Цалин</i>	31
<i>Ядуурал</i>	32
1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ	33
<i>Уур амьсгалын өөрчлөлт</i>	33
1.5. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ	35
<i>Эрх зүйн шинэчлэл</i>	35
<i>Гадаад харилцаа</i>	37
<i>Батлан хамгаалах</i>	41
1.6. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ	43
<i>Дэлхийн эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл</i>	43
<i>Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага</i>	44
<i>Эдийн засгийн 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023 оны төсөөлөл</i> ...	45
1.7. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН	49
1.8. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	54

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирал.....	7
Зураг 2. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, тэрбум ам.доллар.....	7
Зураг 3. Төлбөрийн тэнцэл, гүйцэтгэл, сая ам.доллар	7
Зураг 4. Жилийн инфляц ба суурь инфляц	8
Зураг 5. Инфляцын бүтцийн задаргаа	9
Зураг 6. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд	9
Зураг 7. Цахилгааны хэрэглээ, кВт цаг	15
Зураг 8. Дулаан үйлдвэрлэлийн ачаалал, 2020-2021 он	16
Зураг 9. Дулааны станцуудын хүчин чадал, Гкал, 2020 он	16
Зураг 10. Автотээврийн зорчигчдын тоо, сая хүн	18
Зураг 11. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, мянган тонн	18
Зураг 12. Төмөр зам, агаарын тээврээр тээсэн ачаа, төрлөөр.....	18
Зураг 13. 2021 онд шинээр ашиглалтад оруулсан инженерийн дэд бүтцийн хүртээмж өссөн дүнгээр, км.....	19
Зураг 14. Ипотекийн зээлийн хэмжээ болон зээлдэгчдийн тоо	20
Зураг 15. Жуулчдын зорилго, хандлага	21
Зураг 16. Нийт нас баралт болон эхийн эндэгдлийн харьцаа, жил бүрийн эцэст	24
Зураг 17. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин.....	26
Зураг 18. Боловсролын байгууллага, байршил, өмчийн хэлбэр.....	26
Зураг 19. Шинжлэх ухааны байгууллагад ажиллагчид.....	28
Зураг 20. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил	28
Зураг 21. Шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын бүтэц, эзлэх хувь.....	29
Зураг 22. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, мянган төгрөг	32
Зураг 23. Ядуурлын түвшин, хувиар	32
Зураг 24. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаг, хувиар.....	43
Зураг 25. ОХУ-Украины дайны дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, хувиар	43
Зураг 26. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн	44
Зураг 27. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/трой унц	44
Зураг 28. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн	44
Зураг 29. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/баррель.....	44
Зураг 30. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ.....	45
Зураг 31. Гадаад худалдаа, сая ам.доллар.....	46
Зураг 32. Төлбөрийн тэнцэл, эхний 2 сарын байдлаар.....	47
Зураг 33. Улс орнуудын инфляц болон тэдгээрийн зорилтот түвшин, 2022.III сард	54
Зураг 34. Дэлхийн чингэлэг тээврийн үнийн индекс, 2020 оны 5-р сар = 100.....	55

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй салбаруудын хувь нэмэр, хувиар	6
Хүснэгт 2. Малын тоо, төрлөөр, сая толгой, жил бүр	11
Хүснэгт 3. Мал аж ахуйн салбарын ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх хувь.....	11
Хүснэгт 4. Хураасан ургац, ургамлын төрлөөр, мянган тонн	11
Хүснэгт 5. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, импорт, сая ам.доллар.....	12
Хүснэгт 6. Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, мянган тонн	13
Хүснэгт 7. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тонн	14
Хүснэгт 8. Зам тээврийн салбарын үзүүлэлт	17
Хүснэгт 9. Монгол Улсын автозамын үндсэн мэдээлэл, км	17
Хүснэгт 10. Ашиглалтад орсон орон сууцны тоо	20
Хүснэгт 11. Халдварт өвчин, зарим өвчний төрлөөр, жил бүрийн эцэст, мянган хүн.....	25
Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр	25
Хүснэгт 13. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, сургалтын байгууллагын төрлөөр.....	27
Хүснэгт 14. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдах насны хүн ам.....	27
Хүснэгт 15. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тэтгэвэр авагчдын тоо	29
Хүснэгт 16. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг	30
Хүснэгт 17. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, мянган төгрөг.....	30
Хүснэгт 18. Төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс, мянган төгрөг.....	31
Хүснэгт 19. Цөлжилтийн үйл явцын хандлага, хувь	33
Хүснэгт 20. Ойн нөхөн сэргээх ажил	34
Хүснэгт 21. Улс орнуудын эдийн засгийн өсөлт, хувиар	43

1.1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн өсөлт

Нэрлэсэн ДНБ 2021 онд 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 27.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувиар тус тус өслөө.

Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 5.5 хувиар, барилгын салбар 32.7 хувиар, тээврийн салбар 16.7 хувиар тус тус агшсан нь бодит өсөлт буурахад голлон нөлөөлсөн бол уул уурхайн салбарын өсөлт болон дотоодын эдийн засгийн сэргэлт нь эдийн засгийн агшилтыг хязгаарлахад гол хувь нэмэр оруулсан байна.

Дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт нэмэгдэж, манай улсын уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт 2021 оны эхэнд хурдтай нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж байсан бол оны сүүлд Ковид-19 цар тахлын улмаас хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдож, түүхий эдийн экспорт огцом буурсан нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан байна. Уул уурхайн салбарын өсөлт эхний улирал 39.3 хувь байсан бол оны эцэст 1.7 хувь болж саарсан байна. 2021 онд зэсийн баяжмалын үйлдвэрлэл 4.0 хувиар өсөж, 1,326.4 мянган тонн, газрын тосны үйлдвэрлэл 13.7 хувиар өсөж, 4.7 сая баррельд хүрсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжсэн байна.

ХАА-н салбар 2021 онд 5.5 хувиар буурсан ба үүнд том малын зүй бус хорогдол өндөр байсан нь голлон нөлөөлжээ. Зарим аймгуудад оны эхний улиралд тохиолдсон байгаль, цаг уурын нөхцөл байдал хүндэрснээс шалтгаалан зүй бус хорогдол 2021 онд 45.6 хувиар өсөж, бойжуулсан төл 2020 онтой харьцуулахад 10.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй салбаруудын хувь нэмэр, хувиар


Үзүүлэлт	2018		2019		2020		2021*	
	Өсөлт	Хувь нэмэр	Өсөлт	Хувь нэмэр	Өсөлт	Хувь нэмэр	Өсөлт	Хувь нэмэр
Эдийн засгийн өсөлт	7.7	7.7	5.6	5.6	-4.6	-4.6	1.4	1.4
Хөдөө аж ахуй	6.5	0.9	5.2	0.7	5.8	0.8	-5.5	-0.8
Үйлдвэрлэл	8.5	2.5	3.1	0.9	-4.4	-1.3	-2.8	-0.8
Уул уурхай	5.4	0.9	-1.6	-0.3	-9.9	-1.4	1.7	0.2
Боловсруулах	19.5	1.4	3.8	0.3	3.4	0.3	0.3	0.03
Цахилгаан	8.6	0.2	7.7	0.1	2.6	0	10.6	0.2
Барилга	1.8	0.1	20.3	0.7	-3.2	-0.1	-32.7	-1.3
Үйлчилгээ	5.1	2.4	6.4	2.9	-6.5	-3	3.9	1.8
Худалдаа	0.1	0	10.9	1.2	-12.5	-1.4	9.3	1
Тээвэр	14.6	1	4.4	0.5	-18.2	-0.9	-16.7	-0.5
Бусад	4.8	1.4	4.6	1.3	-2.6	-0.7	4.6	1.3
Цэвэр татвар	20.4	2	9.6	1	-9.4	-1.1	12.2	1.3

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийг нийт эрэлт талаас нь авч үзвэл, 2020 онд 4.4 хувиар агшаад байсан эдийн засгийн нийт эрэлт 2021 онд эргэж сэргэхэд хөрөнгийн хуримтлал 74.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин өрхийн хэрэглээ 2021 онд 1.2 хувиар, бараа үйлчилгээний экспорт 2.0 хувиар тус тус буурсан нь эдийн засгийн эрэлтийг хязгаарласан байна. Хөрөнгийн хуримтлал нэмэгдэхэд материаллаг эргэлтийн хөрөнгийн хуримтлал голлон нөлөөлсөн ба энэ нь 10.0 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд зээл олголт нэмэгдсэн, экспортын түүхий эдийн тээвэр саатсантай холбоотойгоор олборлолт хийгдсэн боловч, экспортод гараагүй бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 онд 16.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 25.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна.

Экспортоор 9.2 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь 2020 оноос 22.1 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор экспортын орлого нэмэгдсэн байна.

Импортоор 6.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд худалдан авсан нь өмнөх оноос 29.4 хувиар өсжээ. Импортын өсөлтөд тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн бүтээгдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмж, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний импорт голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 3. Төлбөрийн тэнцэл, гүйцэтгэл, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцэл 2021 онд 222 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал дансны алдагдал өмнөх оноос 1,284 сая ам.доллараар нэмэгдэж, 1,959 сая ам.долларт хүрсэн бол санхүүгийн дансны ашиг 331 сая ам.доллараар нэмэгдэн 1,835 сая ам.долларт хүрлээ.

Урсгал дансны алдагдал ийнхүү нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал өмнөх оноос 939 сая ам.доллараар нэмэгдсэн, импортын өсөлтөөс шалтгаалан барааны дансны ашиг 453 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө. Харин хөрөнгийн дансны тэнцэл өмнөх оноос 24 сая ам.доллараар нэмэгдэж, 127 сая ам.долларт хүрсэн байна.

Хөрөнгө оруулалтын буцаалтыг оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2021 онд өмнөх оноос 24.0 хувиар өсөж, 2.1 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнд хувьцаа хэлбэрийн хөрөнгө оруулалт 87.0 хувиар өссөн нь нөлөөлжээ. Улсын


бүртгэлийн ерөнхий газрын мэдээллээр 2021 онд нийт 92 гадаадын хөрөнгө оруулалттай ХХК шинээр бүртгүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 21-ээр буюу 30.0 орчим хувиар өссөн үзүүлэлт байна. Харин өрийн хэрэгслээр хөрөнгө оруулалтын урсгал өмнөх оны түвшнээс 171 сая ам.доллараар бага байлаа. ГШХО-ын орох урсгалын дийлэнхийг бүрдүүлдэг Оюу Толгойн хөрөнгө оруулалт 0.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 100 орчим сая ам.доллараар буурсан байна¹.

Өнгөрсөн онд “МИК ОССК” ХХК 250 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд арилжаалж, 2019 онд гаргасан 300 сая ам.долларын бондын тодорхой хувийг дахин санхүүжүүлжээ. Мөн Монгол Улсын Засгийн газар 2021 оны 6 дугаар сард “Century” төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бонд арилжаалж, 2022 онд төлөгдөх Чингис, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондыг дахин санхүүжүүлж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа.

Инфляц

Инфляцын түвшин 2021 оны эцэст улсын хэмжээнд 13.4 хувьтай гарлаа. Инфляцын өсөлтөд тээвэр, логистикийн саатал, тээврийн зардлын өсөлт, худалдааны түнш орнуудын инфляц нэмэгдсэн хүчин зүйлс болон төсөв, мөнгөний тэлэх бодлогын дүнд мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 4. Жилийн инфляц ба суурь инфляц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк


Хүнсний бүлгийн үнэ 2021 онд 20.4 хувиар өссөн нь нийт инфляцын өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Хүнсний инфляц өссөн нь Ковид-19 цар тахалтай иргэдийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний нөөцлөлт, тээвэр логистикийн саатал, олон улсын зах зээл дээрх хүнсний инфляц зэрэгтэй холбоотой байна. Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлт 2021 он гарснаар саарсан хэдий ч суурь үеийн нөлөөгөөр инфляц өсөхөд нөлөөлсөн байна.

Тээврийн бүлгийн үнэ 2021 онд 21.6 хувиар өссөн ба үүнд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтийг даган шатахууны жижиглэнгийн үнэ төрлөөсөө хамааран 2021 онд 37.7-54.4 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүллээ.

Мөн түлшний модны үнийн өсөлт болон “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үнийн зохицуулалттай холбоотойгоор орон сууц, ус, цахилгааны бүлгийн үнэ 2021 онд нэмэгдсэн нь инфляц өсөхөд нөлөөлсөн нэг хүчин зүйл болжээ.

¹ Рио Тинто компанийн 2021 оны тайлан

Зураг 5. Инфляцын бүтцийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Ажил эрхлэлт, ажилгүйдэл

2020 оны сүүлийн улирал болон 2021 оны эхний улиралд нийт 60 хоног хатуу хөл хориотой тогтоосны улмаас ажиллах хүчний оролцооны түвшин 2020 оны 4 дүгээр улиралд 2 нэгж хувиар, 2021 оны 1 дүгээр улиралд 2.1 нэгж хувиар тус тус буурч, 54.9 хувьд хүрсэн.

Засгийн газраас шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг хадгалах зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, хөл хориог үе шаттайгаар сулруулсан нь дотоодын эдийн засаг ялангуяа, үйлчилгээний салбарыг идэвхжүүлж, иргэдийн ажиллах сонирхлыг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн зах зээл сэргэж, 2021 оны 4 дүгээр улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувьд хүрлээ². Түүнчлэн, ажиллагчдын тоо оны эцэст 1 сая 127 мянга болж, 1 дүгээр улиралтай харьцуулахад шинээр 72 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 6. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Ажиллах хүчний оролцооны түвшин



Хөдөлмөр эрхлэлт ба ажиллагчид




² Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар, 1 дүгээр улирлаас 3.4 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

Ажилгүйдлийн түвшин



Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2.БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Мал аж ахуй. Манай улсын мал сүргийн тоо сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж, улсын хэмжээнд 2021 онд нийт 188.5 мянган малчин өрхөд 67.3 сая толгой, хонин толгойд шилжүүлснээр 115.0 сая толгой мал өвөлжсөн урьдчилсан дүн гарсан.

Улсын хэмжээгээр 2021 оны эцэст, мал тооллогын дүнгээр 67.3 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 275.3 мянга (0.4 хувь)-аар өслөө. Үүнээс адуу 4.3 сая, үхэр 5.0 сая, тэмээ 454.0 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая байна. Өмнөх онтой харьцуулахад хонь 1.0 сая (3.5 хувь), үхэр 290.2 мянга (6.1 хувь), адуу 230.6 мянга (5.6 хувь)-аар өссөн бол ямаа 1.3 сая (4.6 хувь), тэмээ 18.9 мянга (4.0 хувь)-аар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Малын тоо, төрлөөр, сая толгой, жил бүр

Он	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Нийт
2018	3.9	4.4	0.5	30.6	27.1	66.5
2019	4.2	4.8	0.5	32.3	29.3	71.0
2020	4,1	4.7	0.5	30.0	27.7	67.1
2021	4.3	5.0	0.5	27.7	26.5	67.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мал аж ахуйн салбарын эзлэх хувь 2020 оны байдлаар 87.2 хувьд хүрлээ.

Хүснэгт 3. Мал аж ахуйн салбарын ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх хувь

Он	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Үүнээс мал аж ахуйн салбар	Эзлэх хувь
2018	5,639.7	4,814.4	85.3
2019	6,548.2	5,675.8	86.6
2020	7,256.7	6,333.0	87.2

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.2 хувиар өссөн бөгөөд малчин өрхийн жилийн дундаж орлого 2021 онд 7.8 хувиар өсөж, 16.5 сая төгрөгт хүрсэн байна.

Газар тариалан. Улсын хэмжээнд 2021 онд 675.1 мянган га талбайд тариалалт хийснээс 614.5 мянган тонн үр тариа, 182.6 мянган тонн төмс, 121.7 мянган тонн хүнсний ногоо, 293.7 мянган тонн таримал тэжээлийн ургамал тус тус хураан авсан байна. Ингэснээр улаан буудай, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 60 хувийг дотоодын ургац хураалтаас хангах боломж бүрдсэн байна.

Хүснэгт 4. Хураасан ургац, ургамлын төрлөөр, мянган тонн

Таримлын төрөл	2018	2019	2020	2021	Өсөлтийн хувь 2021/2020
Үр тариа	453.8	433.3	430.3	614.5	42.8
Үүнээс: Буудай	436.1	411.4	406.1	566.3	39.4
Төмс	168.9	192.2	244.3	182.6	-25.2
Хүнсний ногоо	100.7	99.5	121.2	121.7	0.4
Таримал тэжээл	123.8	121.1	182.1	293.7	61.3
Техникийн ургамал	23.9	34	22.6	52.3	2.3 дахин
Бэлтгэсэн хадлан	1,229.4	1,369.2	1,186.2	1,720.6	45.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд 2021 онд үр тариа 614.5 мянган тонн, төмс 182.6 мянган тонн, хүнсний ногоо 121.7 мянган тонн, таримал тэжээл 293.7 мянган тонн, техникийн ургамал 52.3 мянган тонныг хураан авч, 1.7 сая тонн хадлан, 63.6 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх 2020 оноос бэлтгэсэн хадлан 534.4 (45.1 хувь) мянган тонн, хураасан үр

тариа 184.2 (42.8 хувь) мянган тонн, таримал тэжээл 111.5 (61.3 хувь) мянган тонн, бэлтгэсэн гар тэжээл 21.4 (50.8 хувь) мянган тонн, хураасан хүнсний ногоо 0.5 (0.4 хувь) мянган тонноор тус тус өсөж, харин хураасан төмс 61.6 (25.2 хувь) мянган тонноор буурсан байна.

Хөнгөн үйлдвэрлэл. Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 1,600 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгжид 30.0 мянган ажиллагчидтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт үйлдвэрлэл 2020 оны байдлаар 1.1 тэрбум төгрөгт, борлуулалт 1.0 тэрбум төгрөгт, нийт экспорт 296.3 сая ам.долларт хүрсэн байна.

Хүснэгт 5. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, импорт, сая ам.доллар

Барааны нэр	Экспорт				Импорт			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	409.8	434.6	279.5	370.7	90.2	85.0	85.8	103.7
Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	17.0	14.1	7.4	6.4	8.3	7.1	3.9	6.4
Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл	2.2	3.7	2.2	2.2	8.4	7.8	7.0	24.6
Мод, модон эдлэл	0.3	0.6	0.3	0.1	34.0	43.5	45.4	67.3
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.04	0.05	0.4	0.03	61.6	56.4	53.1	64.3
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.6	1.2	0.6	1.2	226.8	260.3	223.1	260.2
Нийт	430.9	454.2	290.4	380.6	429.3	460.1	418.3	526.5

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын ихэнх хувийг нэхмэл, хувцас үйлдвэрлэл, түүхий эдийн импортын дийлэнх хувийг модон эдлэл, хэвлэл, цаас, картон бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Үүнийг салбараар авч үзвэл:

Сүлжмэл, нэхмэл. Сүлжих, нэхэх эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч цогцолбор 14, жижиг дундын 80 гаруй үйлдвэрт ээрэх үйлдвэрээс гарсан 800 гаруй тонн ээрмэл утсаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байгаагаас эцсийн бүтээгдэхүүний 60.0 хувийг экспортод, 40.0 хувь нь дотоодод борлуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, 10.0 мянга гаруй тонн ноолуур бэлтгэж, үүний 1.7 мянган тонн буюу 17.0 орчим хувь нь нэмүү өртөг шингэсэн бэлэн бүтээгдэхүүн болж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийн 80 гаруй сүлжмэлийн үйлдвэрт жилдээ 900 мянган ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмж суурилуулснаас 53.0 хувийг нь ашиглаж байгаа бөгөөд 1.0 мянга гаруй хүн ажиллаж байна.

Ноос, ноолуур. Ноос боловсруулах салбарт жилдээ 38.8 мянган тонн ноос угаах, 934 мянган ширхэг сүлжмэл, 600 мянган метр квадрат ноосон даавуу, 1.6 сая метр хивс үйлдвэрлэх, 800 мянган метр дулаалгын материал үйлдвэрлэх, 3 мянган тонн ноосон бордоо үйлдвэрлэх, 1.2 сая метр шивмэл эсгий, 2.3 сая метр эсгий үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан байна. Ноолуур угаах 34 үйлдвэрт суурилагдсан хүчин чадал 13.0 мянган тонн байгаагийн 77 хувийг нь ашиглаж, 400 орчим хүнийг ажлын байраар хангаж байна. Угаасан ноолуурын хялгасыг нь ялгах 36 үйлдвэрт 5.8 мянган тонн, самнасан ноолуур гаргах хүчин чадал бүхий тоног төхөөрөмж суурилуулснаас 26 хувийг нь ашиглаж байгаа бөгөөд 700 орчим хүн ажиллаж байна. Ээрмэлийн 16 үйлдвэрт 2.2 мянган тонн ээрмэл гаргах хүчин чадал бүхий тоног төхөөрөмж суурилуулсан боловч, 31 хувийг нь ашиглаж байна.

Арьс, шир. Арьс, шир боловсруулах салбарт жилдээ 18 сая ширхэг хагас боловсруулсан арьс шир үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмж суурилуулснаас 33.8 хувийг нь ашиглаж байна. Харин 2.5 сая ширхэг гүн боловсруулсан арьс, шир үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмж суурилуулснаас 68 хувийг нь ашиглаж байна.

Мод, модон бүтээгдэхүүн. Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлд 450 гаруй аж ахуйн нэгж байгууллага мод бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 3-4 хувийг үйлдвэрлэж байна. Мод бэлтгэл, зүсмэл материалын 110, барилгын модон хийцийн 24, хавтан хийцийн мебель тавилгын 70, зөөлөн тавилгын 12, гэрийн модны 50, хөгжмийн зэмсгийн 6, шахмал түлшний 16, жижиг мужааны 180 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 6.0 мянга гаруй хүнийг ажлын байраар хангаж байна.

Хүнсний үйлдвэрлэл. Нийслэлийн хүн амын 2021-2022 оны өвөл, хаврын улирлын махны нөөц бүрдүүлэх арга хэмжээнд 24 аж ахуйн нэгж, нийт 13.0 мянган тонн мал, мах бэлтгэхээр хүсэлтээ ирүүлснээс өнөөгийн байдлаар нийт 10.1 мянган тонн махыг бэлтгэж, нөөцөлсөн байна.

Импортын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн. Монгол Улсын зах зээл дээр 27 нэр төрлийн хүнсний нарийн ногоо хоногт 80.0 тонн, 17 төрлийн жимс, жимсгэнэ хоногт 50.0 тонн худалдаалагддаг бөгөөд хүнсний нарийн ногоо, жимс, жимсгэнэ 90.0 хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Жижиг, дунд үйлдвэр. Монгол Улсад 63.0 мянга гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч байгаа бөгөөд нийт аж ахуйн нэгжийн 84.0 хувийг эзэлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэр

Уул уурхай. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 6.15 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 2,638 тусгай зөвшөөрөл, үүнээс 1.77 сая га талбай бүхий 1,745 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 4.38 сая га талбай бүхий 893 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Нийт газар нутгийн 2.8 хувийг хайгуулын тусгай зөвшөөрөл, 1.1 хувийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 13,362.3 тэрбум төгрөг болж, 2020 оны мөн үеэс 4,294.1 тэрбум төгрөг буюу 47.4 хувиар өссөн байна. Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 3,955.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,025.9 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өссөн байна. Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 29.6 хувийг бүрдүүлж байна.

Улсын төсөвт уул уурхайн салбараас 3,707.8 тэрбум төгрөг буюу 27.7 хувийн, газрын тосны салбараас 180.4 тэрбум төгрөг буюу 1.4 хувийн, тусгай зөвшөөрлийн төлбөр 30.8 тэрбум төгрөг буюу 0.2 хувийн, бусад орлого 36.9 тэрбум төгрөг буюу 0.3 хувийн орлого бүрдүүлсэн байна.

2021 оны эхний 11 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал 60.2 мянган тонн буюу 5.2 хувиар, молибдены баяжмал 342.0 тонн буюу 6.2 хувиар тус тус өссөн бол нүүрс 9,093.4 мянган тонн буюу 24.7 хувиар, алт 837.9 кг буюу 4.5 хувиар, төмрийн хүдэр 99.3 мянган тонн буюу 1.1 хувиар, төмрийн хүдрийн баяжмал 772.0 мянган тонн буюу 18.0 хувиар, хайлуур жоншны хүдэр 8.6 мянган тонн буюу 7.3 хувиар, хайлуур жоншны баяжмал 5.5 мянган тонн буюу 8.7 хувиар, цайрын баяжмал 0.2 мянган тонн буюу 0.3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, мянган тонн

Бүтээгдэхүүн	2020.XI	2021.XI	Өсөлтийн хувь 2021.XI/2020.XI
Нүүрс	36,743.3	27,649.9	-24.7
Зэсийн баяжмал	1,162.9	1,223.1	5.2
Алт (кг)	18,766.4	17,928.5	-4.5
Молибдены баяжмал	5,500.0	5,842.0	6.2
Төмрийн хүдэр	8,718.2	8,618.9	-1.1
Төмрийн хүдрийн баяжмал	4,283.3	3,511.3	-18.0
Хайлуур жоншны хүдэр	118.2	109.6	-7.3
Хайлуур жоншны баяжмал	62.8	57.3	-8.8
Цайрын баяжмал	68.6	68.4	-0.3

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Геологи. Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчныг бүрдүүлэх, геологи, эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор гүйцэтгэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, уул уурхайн салбарыг ашигт малтмалын найдвартай нөөцөөр хангаж үйл ажиллагааг тогтвортой байлгах замаар Монгол Улсын эдийн засгийн суурь үндсийг бэхжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Геологийн салбарын хүрээнд төсвийн хөрөнгөөр 2018 онд 13.1 тэрбум төгрөг, 2019 онд 23.7 тэрбум төгрөг, 2020 онд 20.2 тэрбум төгрөг, 2021 онд 24.1 тэрбум төгрөг, нийт 81.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 47, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 3, сэдэвчилсэн судалгааны 21 төслийг үндэсний 57 аж ахуйн нэгж хийж гүйцэтгэсэн.

Улсын Их Хурлаас 32.9 тэрбум төгрөг баталсан бөгөөд 2022 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 35, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг нэгтгэх 2, сэдэвчилсэн судалгааны 23, нийт 60 төслийг үргэлжлүүлэн болон шинээр эхлүүлэн ажиллаж байна.

Газрын тосны салбар. Газрын тосны салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний хагаст 430.8 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 0.94 хувийг эзэлж байна. Газрын тос 5 боомтоор импортлогдож байна.

Ерөнхий сайдын 2021 оны 122 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, тулгамдсан асуудлуудыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгийг Шадар сайдаар ахлуулан байгуулж ажилласан.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ажлыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хэрэгжүүлж ажилласан бөгөөд үйлдвэрийг бүтээн байгуулах ажлыг БНЭУ-ын Экспорт-Импортын (Эксим) банк, төслийн менежментийн зөвлөх компанитай зөвшилцөн технологийн бус барилга байгууламж, анхдагч процессын болон дагалдах байгууламж, үйлдвэрийн цахилгаан станц, лицензэд технологийн байгууламж гэж 4 хэсэгт хуваан хэрэгжүүлсэн. “Технологийн бус барилга байгууламж” ажлын хүрээнд үйлдвэрийн усан хангамжийн байгууламжууд, оффис, гал команд, хоолны газар, лаборатори, агуулах, засварын цех, анхны тусламжийн барилгууд, үйлдвэрийн талбайд зам, сувагчлал, үерийн ус зайлуулах систем зэрэг байгууламжийн барилга угсрах бэлтгэлийг 2021 оны нэгдүгээр сараас хангаж, газар шорооны ажлын ухмалын хэсэг бүрэн дуусаж, суурийн хэв хашмал, арматурчлалын ажил, ус дамжуулах хоолой, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын газар шорооны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүнд үйлдвэр. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2021 оны эхний 8 сарыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрсний үйлдвэрлэл 78.7 хувиар өссөн бол ган төмөр хийцийн үйлдвэрлэл 32.4 хувиар буурсан.

Хүснэгт 7. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тонн

№	Бүтээгдэхүүний төрөл	2020.I-VIII	2021.I-VIII	Өсөлтийн хувь 2021.VIII/ 2020.VIII
1	Нүүрсэн шахмал түлш	16	449.6	78.7
2	Катодын зэс	684.2	6,710.9	8.6
3	Металл бэлдэц	72.1	23,356.3	2.0
4	Металл цувимал		23,209.9	2.2
5	Ган төмөр хийц	380.6	2,589.6	-32.4

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Коксын экспорт. 2021 оны эхний 8 сарын байдлаар 8.4 сая ам.долларын 32.3 мянган тонн кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 8.2 сая ам.доллар буюу 40.9 дахин, биет хэмжээгээр 31.0 мянган тонн буюу 25.3 дахин тус тус өссөн байна.

Катодын зэс. 2021 оны эхний 8 сарын байдлаар 62.3 сая ам.долларын 7,045.4 тонн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1,041.2 тонн буюу 17.3 хувиар, үнийн дүнгээр 29.9 сая ам.доллар буюу 92.1 хувиар тус тус өссөн байна. 1 тонн катодын зэсийн экспортын дундаж үнэ 8,842.1 ам.доллар болж, 3,440.5 ам.доллар буюу 63.7 хувиар өссөн байна.

Эрчим хүч


Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем төвийн, өмнөд, баруун, дорнод, Алтай-Улиастайн гэсэн 5 хэсгээс бүрдэж, Монгол орны хот, сум, суурин газруудыг цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Монгол Улс 2021 онд 9.7 тэрбум кВт цаг цахилгаан эрчим хүч боловсруулж, 8.9 тэрбум кВт цаг цахилгаан эрчим хүч, 11.0 сая Гкал дулааны эрчим хүч түгээв. Нийт цахилгаан эрчим хүч түгээлтийн 88 хувийг дотоодын үйлдвэрлэл, 12 хувийг импорт бүрдүүлж байна. Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийн эх үүсвэрийг бүтцээр авч үзвэл, 90.9 хувийг дулааны цахилгаан станц (ДЦС), 9.07 хувийг нар, салхи, усны эх үүсвэр, 0.03 хувийг дизель станц тус тус үйлдвэрлэж байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-8 хувиар өссөн бөгөөд төрөөс цахилгааны төлбөрийг тэглэх шийдвэр гаргаснаар 2021 онд хэрэглээ 11.0 хувиар нэмэгдсэн. Хэрэглээний өсөлтийг хангахад Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын 1-4 дүгээр турбогенераторын шинэчлэлтийн төслөөр 2021 онд суурилагдсан хүчин чадлыг 46 МВт-аар нэмэгдүүлж, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг 35 МВт-аар өргөтгөх төслийг хэрэгжүүлсэн нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

Цахилгаан эрчим хүчний түгээлт 2022 онд 9.1 тэрбум кВт цаг буюу 0.2 тэрбум кВт цагаар нэмэгдэх тооцоотой байгаа бөгөөд үүний 7.0 тэрбум кВт цагийг дотоодын эх үүсвэрээс, 2.1 тэрбум кВт цаг (нэмэгдэх 0.2 тэрбум кВт цаг)-ийг импортоор хангахаар төлөвлөсөн.

Зураг 7. Цахилгааны хэрэглээ, кВт цаг




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Манай улсад 1 кВт цаг цахилгаан эрчим хүчний үнэ дунджаар 6.2-6.3 ам.цент байгаа нь хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-ын цахилгааны үнээс 1.3-1.5 дахин, бусад хөгжилтэй орнуудаас 4-5 дахин хямд байна. Айл өрхийн нэг сарын эрчим хүчний төлбөр нь өрхийн нийт зардлын 5.5 хувийг эзэлдэг байна. Өнөөгийн байдлаар 1 кВт цаг цахилгаан эрчим хүчний өртөг 183.65 төгрөг байхад борлуулалтын тариф 134.28-154.08 төгрөг/кВт цаг буюу өдөр шөнийн хэрэглээнээс хамааран өөрийн өртгөөс 31-63 хувиар доогуур түвшинд байна.


Оргил ачааллын үед станцууд бүрэн хүчин чадлаас давсан дулааныг үйлдвэрлэж байна. Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 11.0 сая.Гкал дулаан үйлдвэрлэж, 10.7 сая.Гкал дулаан хэрэглэсэн нь жилийн хугацаанд хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа боловч, өвлийн оргил ачааллын үед нэгдсэн сүлжээнд дарамт нэмэгдэж, өмнөх оноос 6 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн ачаалал 2020-2021 оны өвлийн улиралд 118 хувьтай байв.

Зураг 8. Дулаан үйлдвэрлэлийн ачаалал, 2020-2021 он



Эх сурвалж: Эрчим хүчний яам

Зураг 9. Дулааны станцуудын хүчин чадал, Гкал, 2020 он



Эх сурвалж: Эрчим хүчний яам

ДЦС-уудын 40.0 орчим хувь, хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн дулаан дамжуулах гол шугамуудын 30.0 орчим хувь, түгээх сүлжээний 51,927 км цахилгаан дамжуулах шугам, дэд станцын 30.0 хувь нь тус бүр гучаас дээш жилийн насжилттай, ашиглалтын хугацаа дууссан тоноглолыг ашиглаж байгаа нь шугамын алдагдлыг нэмэгдүүлж байна. Станцууд хүчин чадлаасаа давсан үйлдвэрлэл явуулахын зэрэгцээ ашиглалтын жил дууссан болон дуусаж байгаа нь ирээдүйд эрчим хүчний нийлүүлэлтийг тогтворгүй болгож болзошгүй байна.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын дулааны үйлдвэрлэл жилд дунджаар 4.0 хувиар, аймаг, суурин газрын дулааны үйлдвэрлэл жилд 9.9 хувиар нэмэгдсэн. Иймд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэр эрэлхийлэх, станц барих, шугамын алдагдлыг бууруулах хэрэгтэй байна.

Монгол Улсын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлын 81.5 хувийг ДЦС эзэлж байна. Үүнээс үүдэн нүүрсний хэрэглээ нэмэгдсээр 2021 онд улсын хэмжээнд эрчим хүч үйлдвэрлэлд 7.5 сая.тонн нүүрс хэрэглэсэн ба жилд дунджаар 5-7 хувийн өсөлттэй байна. Цаашид шинээр баригдах эх үүсвэрүүд болон одоогийн станцуудын өргөтгөлд нүүрсний хэрэглээ огцом өсөх төлөвтэй байна.

Монгол Улсын хэмжээнд 8,299 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 105 км дэд станц, 51,927 км цахилгаан түгээх шугам, 12,294 дэд станц байгаагаас Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Баян-Өлгий аймгийн төв, Ховд аймгийн Манхан суманд байрлах дэд станцууд болон Улаанбаатар хотын 110 кВ-ын 12 дэд станц 75-95 хувийн, Булган А, Б, Мөрөн, Бор-Өндрийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 90-96 хувь хүртэл ачаалагдаж байна. Үүнээс шалтгаалан хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх боломжгүй, оргил ачааллын үед хязгаарлах горимд хүргэж байна.

Монгол Улсын хэмжээнд 155 МВт-ын салхин цахилгаан станц, 90 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. Салхины станцуудын системийн түгээлтэд эзлэх хувь 7.5 хувь, төлбөр тооцоонд эзлэх хувь 17.3 хувь, нарны эх үүсвэрүүдийн эзлэх жин 1.4 хувь, төлбөр тооцоонд эзлэх хувь 6.8 хувь ба нийт дүнгээр нар салхины эх үүсвэрүүд үйлдвэрлэлийн 9.2 хувь, төлбөр тооцооны 24.2 хувийг эзэлж байна.

Зам, тээвэр

Бүх төрлийн тээврээр 60.5 сая тонн ачаа 2020 онд тээвэрлэсэн нь өмнөх оноос 8.5 (12.4 хувь) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 10.4 (25 хувь) сая тонн, агаарын тээврээр тээсэн ачаа 3.3 (55 хувь) мянган тонноор буурсан нь голлон нөлөөлжээ. Манай улсын экспортын бараанд овор ихтэй уул уурхайн түүхий эд зонхилдог ба 2020 онд экспортын 70 хувь нь автозамаар тээвэрлэгдсэн бол импортын 70 хувь нь төмөр замаар тээвэрлэгдсэн байна. Иймд байгаль орчинд хохиролгүй, экспортыг нэмэгдүүлэхэд төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 8. Зам тээврийн салбарын үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	Өсөлтийн хувь 2020/2019
Нийт тээвэрлэсэн ачаа, мянган тонн	53,983.4	67,802.9	68,997.5	60,458.8	-12.3
Төмөр зам	22,765.1	25,763.3	28,143.0	30,001.2	6.6
Авто зам	31,212.9	42,033.8	40,848.8	30,454.9	-25.4
Агаарын зам	5.4	5.8	5.8	2.7	-53.4
Нийт зорчигчдын тоо, сая хүн	216.1	197.0	173.0	126.5	-26.9
Төмөр зам	2.6	20.6	3.0	2.0	-33.3
Авто зам	212.2	193.0	168.4	124.1	-26.3
Агаарын зам	1.3	1.4	1.60	0.4	-75.0
Усан зам	0.0	0.0	0.0	-	-
Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг	1,422.2	1,754.4	2,003.5	1,504.9	-24.9
Төмөр зам	530.0	616.0	708.6	775.9	9.5
Авто зам	506.4	695.9	796.1	564.4	29.1
Агаарын зам	385.5	442.3	498.2	161.1	67.7
Усан зам	0.3	0.5	0.4	0.5	25.0

Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Автозам. Монгол Улсын нутаг дэвсгэр үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2020 оны жилийн эцсээр 111,916.7 км байгаагийн 99,978.6 км нь буюу 89.3 хувь нь ердийн хөрсөн, 11,938.1 км буюу 10.7 хувь нь сайжруулсан зам байна. Нийт сайжруулсан замын 10,125 км буюу 84.8 хувийг хатуу хучилттай, 1,207.9 км буюу 10.1 хувийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5.1 хувийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. Улсын чанартай автозамын 86 хувь нь орон нутгийн, 1 хувь нь уул уурхайн зам байна. Нийт хатуу хучилттай автозамын урт 10,151 км байна.


Хүснэгт 9. Монгол Улсын автозамын үндсэн мэдээлэл, км

Үзүүлэлт	2018	2019	2020
Авто замын сүлжээний нийт урт	111,916.7	111,916.7	111,916.7
Улсын чанартай авто зам	14,918.7	14,918.7	14,918.7
Ердийн хөрсөн зам	101,081.2	100,297.6	99,952.93
Сайжруулсан хөрсөн	604.9	604.9	604.9
Хайрган хучилттай	1,207.89	1,207.89	1,207.89
Хатуу хучилттай	9,023	9,806	10,151
Асфальт бетон	8,706.4	9,490	9,834.6
Хөнгөвчилсөн хар	205.2	205.2	205.2
Цемент бетон	111.16	111.16	111.16

Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам


Автотээврээр тээвэрлэсэн ачаа 2019 оныг хүртэл тогтмол өсөж байсан ч, цар тахлаас үүдэн хил хаасан, хөл хорио тогтоож, үйлчилгээ эрхлэгчид түр хугацаагаар зогссон нь нийт ачаа тээврийн эргэлтийг бууруулсан.

Зураг 10. Автотээврийн зорчигчдын тоо, сая хүн



Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Зураг 11. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, мянган тонн




Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Авто замын салбарын нийт хөрөнгө оруулалтын 93.3 хувийг авто зам, гүүрний барилга, 6.4 хувийг замын урсгал засвар, 0.2 хувийг зураг төсөл, 0.1 хувийг судалгаа шинжилгээний ажилд тус тус зарцуулж ирсэн байна. Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засварт зарцуулсан хөрөнгө сүүлийн 17 жилийн дунджаар нийт хөрөнгө оруулалтын 6.4 хувийг эзэлж байгаа бөгөөд арчлалт, урсгал засварт зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэхгүй байгаа нь зам, замын байгууламжийн ашиглалтын түвшин муудахад нөлөөлж байна. Сүүлийн 15 жилд авто зам, гүүрний барилгын ажилд зарцуулж байгаа хөрөнгө 11.9 дахин өссөн байхад засвар арчлалтад зарцуулж буй хөрөнгө 2.5 дахин өсжээ.

Төмөр зам. Төмөр замын тээврээр 2021 оны эхний 10 сард 26.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.8 сая тонн (7.1 хувь)-оор өсөв.

Зураг 12. Төмөр зам, агаарын тээврээр тээсэн ачаа, төрлөөр



Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбох дэд бүтэц. Монгол Улсад ОХУ-тай хиллэдэг хэсэгт 29, БНХАУ-тай хиллэдэг хэсэгт 13, агаарын замын 4, нийт 46 боомт үйл ажиллагаа явуулж байгаагаас 14 нь олон улсын, 11 нь хоёр талын байнгын ажиллагаатай, 14 нь хоёр талын түр буюу улирлын ажиллагаатай, 7 нь дамжин өнгөрөх боомт байна. Эдгээр боомтын 39 нь авто замын, 3 нь төмөр замын, 4 нь агаарын замын боомт байгаагаас авто замын байнгын ажиллагаатай 13 боомт байна. Сүүлийн 5 жилд хилийн боомтоор нийт 17 сая зорчигч, 6.5 сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх 5 жилтэй харьцуулахад зорчигчдын тоо 2.1 дахин, тээврийн хэрэгсэл 2.0 дахин өссөн бөгөөд цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул хилийн боомтуудын дэд бүтэц, хүчин чадлыг сайжруулах, нэвтрэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлага үүсэж байна.

Өнгөрсөн хугацаанд Ковид-19 цар тахлын тохиолдлын тоо өндөр байснаас үүдэн БНХАУ-ын талаас хилээр нэвтрэх автомашины тоонд хязгаарлалт тогтоосон нь гадаад худалдааны эргэлтэд сөргөөр нөлөөлсөн. Тухайлбал, 1 өдөрт Замын-Үүд боомтоор импортын 50 машин, Шивээхүрэн боомтоор нүүрсний экспортын 90 машин нэвтрэх хязгаарлалтыг тогтоосон. Хоёрдугаар улиралд хилийн боомт байрладаг аймгуудад халдварын тохиолдлууд нэмэгдэж, боомтын үйл ажиллагаа саатсанаар гадаад эрэлтийн өсөлт саарсан нь эдийн засгийн өсөлт саарах үндэс болж байна.

Барилга, хот байгуулалт


Дэлхийн улс орнуудад Ковид-19 цар тахлаас үүдэн бүтээн байгуулалтын ажлууд идэвхжиж, олон улсын тээвэр логистик, хилийн боомтын халдвар хамгаалалтаас үүссэн нөхцөл байдал, барилгын материалын үнэ ханшны өөрчлөлт, хомсдол, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсөвт өртөг нэмэгдэж байна. Барилгын материалын үнийн өсөлтөд гадаад зах зээл дэх материал, түүхий эдийн үнийн өсөлт, хилийн боомт дахь хорио цээрийн үеийн нэвтрүүлэлт, түүхий эдийн татан авалтын саатал, гадаад ажилчдын татан авалт, ханшны өөрчлөлт, тээвэрлэлт, дотоодын халдвар хамгаалалтын дэглэмийн түвшнээс хамаарсан хөл хорио зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна.

Барилга, барилгын материалын үйлдвэрлэл. Сүүлийн 10 жилд өсөлттэй байсан барилгын салбарын үйлдвэрлэл цар тахлаас үүдэлтэй бүтээн байгуулалтын удаашралаас шалтгаалан 2021 онд ДНБ-ий 2.7 хувийг эзэлж байна. Салбарын үйлдвэрлэлийн 28.7 хувийг орон сууцны барилга, 36.0 хувийг орон сууцны бус барилга, 32.4 хувийг инженерийн байгууламж, 2.9 хувийг их засвар тус тус бүрдүүлж байна.

Харин барилгын материал, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, чанарт жилээс жилд ахиц дэвшил гарч, үйлдвэрлэлийн хүчин чадал цементийн хувьд 6 дахин, бетон хийц, эдлэлийн хувьд 4 дахин, хөнгөн бетоны хувьд 2 дахин нэмэгдсэнээр барилгын гол, нэр төрлийн түгээмэл хэрэглэгддэг бетон, төмөр бетон болон барилгын дүүргэлтийн материал, хаших бүтэц, дулаалгын материалын хэрэгцээг 100 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшинд хүрсэн.

Инженерийн дэд бүтэц. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийтийн аж ахуйн салбарт тусгай зөвшөөрөл бүхий 140 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж, хоногт дунджаар 550 гаруй мянган м³ цэвэр усыг олборлон хүн ам, үйлдвэр аж ахуйн газрын унд ахуйн хэрэгцээнд түгээж, хэрэглээнээс гарсан 400 гаруй мянган м³ бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үйлчилгээ үзүүлж байна.

Зураг 13. 2021 онд шинээр ашиглалтад оруулсан инженерийн дэд бүтцийн хүртээмж өссөн дүнгээр, км



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Салбарын хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн эзэмшилд цэвэр усны шугам сүлжээ 3,692 км, бохир усны 1,710 км бүртгэгдсэн байна. Үүнийг 2020 онтой харьцуулахад цэвэр усны шугам 19 км-ээр, бохир усны шугам 32 км-ээр тус тус нэмэгдсэн байна.

Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогоор 2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 897.4 мянган өрх байгаагаас 411.4 мянган өрх буюу нийт өрхийн 45.8 хувь нь нийслэлд амьдарч байна. Үүний 201.6 мянган өрх нь инженерийн дэд бүтэц бүхий орон сууц болон бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа бол үлдсэн 209.8 мянган өрх буюу 50.9 хувь нь инженерийн дэд бүтэцгүй амины орон сууц болон уламжлалт гэр сууцанд амьдарч байна. Нийслэлийн хэмжээнд амьдарч байгаа нийт 411.4 мянган өрхийн 10.3 хувь буюу 42.3 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаагаас 5.5 хувь нь бусдын сууцанд түрээстэй, 4.4 хувь нь бусдын сууцанд түрээсгүй амьдарч байна.

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт 196 барилга, 13,417 өрхийн орон сууц ашиглалтад орсон байна. Үүнээс Улаанбаатар хотод 137

барилга, 11,434 орон сууц ашиглалтад орсон бол орон нутагт 59 барилга, 1,983 айлын орон сууц ашиглалтад оржээ.

Хүснэгт 10. Ашиглалтад орсон орон сууцны тоо

№	Байршил	2015	2016	2017	2018	2019	2020	2021
1	Орон нутаг нийт	5,627	2,704	1,365	1,461	1,972	3,173	1,983
2	Улаанбаатар	18,102	16,128	9,658	9,700	12,027	12,466	11,434
Улсын хэмжээнд нийт		23,729	18,832	11,023	11,161	13,999	15,639	13,417

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн А-392 дугаар тушаалаар шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувь байсныг жилийн 6 хувь болгож бууруулсан бөгөөд энэ арга хэмжээний үр дүнд зээлдэгчийн сарын эргэн төлөлтийн хэмжээ болон орлогын доод хэмжээ тус тус 18.3 хувиар буурч, ипотекийн зээлийн шалгуурт тавигддаг өрхийн орлогын хэмжээ нийслэлийн өрхийн дундаж орлогын түвшнээс бага түвшинд очсоноор ипотекийн зээлд орлого багатай өрхийн хамрагдах боломж нэмэгдэх, цар тахлын эрсдэл өндөр үед зээлийн дарамтыг бууруулах, өрхийн амьжиргаа нэмэгдэх, зээлийн эрсдэл буурах зэрэг эерэг нөхцөл бүрдсэн.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлж 2021 оны жилийн эцэст 1,012 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 13,292 зээлдэгчид олголоо. Мөн ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах замаар урьдчилгаа төлбөрийн хэмжээг бууруулж, хувилбарт ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан.

Зураг 14. Ипотекийн зээлийн хэмжээ болон зээлдэгчдийн тоо



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газраас ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох, урьдчилгаа төлбөрийн хэмжээг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд харин ипотекийн зээлийн шаардлага хангахгүй иргэдийг түрээсийн болон түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцаар хангах чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэхээр шинээр орон сууцны хороолол барих ажлыг эрчимжүүлээд байна.


“Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, захиалагч, зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг БНСУ-ын Экспорт-Импортын банкны холбогдох журмын дагуу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулж, төслийг эхлүүлэв. Төслийн Эскиз зураг боловсруулагдаж, 2022 оны 2 дугаар улиралд барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

“Залуус-1” орон сууцны цогцолбор хорооллыг Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын “ТОСК” ТӨХХК-ийн 57 га талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн төлөвлөгөө, ажлын зураг төсөл зэрэг бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Аялал жуулчлал

Улсын хэмжээнд 2021 онд гадаадын жуулчдын тоо 39.2 мянгад хүрч, өмнөх оноос 27.7 мянга (41.4 хувь)-аар буурч, салбарын орлого 24.0 сая ам.долларт хүрсэн байна.

Зураг 15. Жуулчдын зорилго, хандлага



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Цар тахлаас үүдэн сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхийн аялал жуулчлалын болон жуулчдын аяллын зорилго, сонголтын төлөв байдал өөрчлөгдөж байна. Монгол Улсад 2019 оны байдлаар жуулчдын 72 хувь нь амралтаар, 10 хувь нь албан ажлаар, 6 хувь гэр бүл болон найз нөхдийндөө зочлохоор, 3 хувь нь суралцахаар, 2 хувь нь бал сар тэмдэглэхээр ирсэн бол энэ хандлага өөрчлөгдөж, 34 хувь нь байгалийн сайханд зугаалахаар, 25 хувь нь уламжлалт соёлтой танилцахаар 12 хувь нь адал явдал эрэлхийлэх сонирхолтой болсон байна.

Харилцаа холбоо

Цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэх, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлага, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зорилготой Цахим гарын үсгийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль, хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль, хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Кибер аюулгүй байдлын тухай хууль зэрэг цахим хөгжлийн багц хуулийг Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд хөдөө, орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, техник технологийн суурь дэд бүтцийг өргөтгөж, шилэн кабелийн сүлжээ урт 49.9 мянган км, радио релейний сүлжээний тархалт 8,400 км-т хүрч, манай улсын бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрууд суурин болон хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдлоо.

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2002 онд 235.0 мянга байсан бол 2021 онд 4 сая 608 мянгад хүрч, 100 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчийн тоо 177 болсон нь хөгжиж буй орнуудын болон дэлхийн дунджаас харьцангуй өндөр байна. Хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологийг 2016 онд нэвтрүүлэн одоогийн байдлаар 2 сая 900 мянга гаруй хэрэглэгчтэй боллоо.

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрсэн 26 жилийн хугацаанд 70 гаруй компани интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 780 Гбит/сек, интернэт хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор 5,450.6 мянгад хүрснээс 94.4 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээг хэрэглэж байна.

Өнөөдөр улс орон даяар урт, дунд, богино долгионы их чадлын 6 станцаар үндэсний олон нийтийн радиогийн өргөн нэвтрүүлгийн 1, 2 дугаар программыг дамжуулж, нийт нутаг дэвсгэрийн 90.0 гаруй хувь нь дунд сонсголын, хүн амын 75.0 хувь нь найдвартай сонсголын бүсэд хамрагдаж байна.

Монгол Улсын шуудангийн салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэж, зах зээлийн өрсөлдөөн нэвтэрсэн ба шуудангийн үйлчилгээний хүртээмжийн чанар жилээс жилд сайжирч, улсын хэмжээнд 2021 оны байдлаар 95 аж ахуйн нэгж, байгууллага шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж, дэлхийн 192 улстай агаараар шуудан солилцож байна. Дэлхийн шуудан холбооны байгууллагаас гаргадаг шуудангийн хөгжлийн индексээр Монгол Улс 2020 онд 115 дугаар байр, 2021 онд 57 дугаар байрыг эзэлжээ.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орлого нь 2008 онд 365 тэрбум төгрөг байсан бол жил бүр тасралтгүй өссөөр 2021 онд 1 их наяд 602 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд ДНБ-ний 3.8 хувийг бүрдүүлж байна.

“И-Монгол” төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан төрийн 59 байгууллага, хувийн хэвшлийн 163 байгууллага холбогдон төрийн байгууллагаас үзүүлдэг 606 нэр төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Энэхүү нэгдсэн системээр 2021 онд давхардсан тоогоор нийт 6.8 сая иргэн үйлчлүүлсэн бөгөөд нэг үйлчилгээг авахад дунджаар 5 минутын хугацаа зарцуулжээ. Иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцох, төрийн нээлттэй мэдээлэлд хандах, ашиглах, үнэ цэнийг нь өсгөх, төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлснээр цахим шилжилтийг хурдасгах шаардлага нэмэгдсээр байна.

Ковид-19 цар тахлын үед оюутан сурагчдын алсын зайн сургалт, олон нийтэд албан ёсны эх сурвалжийн нэгдсэн мэдээллийг хүргэх, онцгой нөхцөлд ажиллаж байгаа албан хаагчдыг харилцаа холбооны үйлчилгээгээр хөнгөлөлттэй нөхцөлөөр хангаж дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулан www.econtent.edu.mn цахим сайтад байрласан теле хичээлийг гар утаснаас болон өрхийн интернэтээр, мөн хичээл, сургуулийн хөл хориотой холбоотой сурагч багачуудад зориулан IPTV видео сангаас Боловсрол, шинжлэх ухааны яамны “Теле хичээл”-ийг тодорхой хугацаанд үнэгүй үзэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд одоогийн байдлаар давхардсан тоогоор 30.0 сая гаруй хэрэглэгч 2 сарын турш үзсэн байна.

МУИС, СЭЗИС, АШУҮИС зэрэг нийт 11 их, дээд сургуулийн цахим хичээл явуулдаг порталыг үнэгүй болгосны зэрэгцээ оюутан залуус өөрийн сургуулийн цахим сайт руу хэрэглээний болон хурдны хязгааргүйгээр хандаж, дата ашиглан хичээлээ хийх, зарим тохиолдолд үнэгүй ашиглах шинэ багцыг худалдаанд гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 283 дугаар тогтоолоор төрийн цахим шилжилтийг дэмжиж, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах талаар судалгаа хийх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн технологийн чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах-1111” төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэг “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгууллаа.

1.3. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Монгол Улсын хүн ам 2020 онд 3.4 сая болж, 2010 оноос 0.6 сая хүнээр нэмэгдэж, 2020 оны байдлаар хүн амын өсөлт дунджаар 1.8 хувьтай байна. Хүн амын бүлгээр авч үзвэл, нийт хүн амын 37.1 хувийг хүүхэд, 30.7 хувийг залуучууд, 62.6 хувийг хүүхэд, залуучууд /0-34 нас/ эзэлж байгаа бол 9.8 хувийг ахмад настан, 3.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна. Хүн амын байршлын хувьд хот, суурин газар нийт хүн амын 69.0 хувь нь аж төрж байгаа бол Улаанбаатар хотод 47.6 хувь байна. Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2009-2020 онд дунджаар 0.3 жилээр нэмэгдэж ирсэн бөгөөд 2020 оны байдлаар 70.71 (эрэгтэйчүүд 66.71, эмэгтэйчүүд 76.22) байна.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй 108.4 мянган хүн байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 42.4 хувь нь төрөлхийн, 57.6 хувь нь олдмол шалтгаантай бөгөөд 0-18 насны 12.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 61.2 мянга буюу 56.4 хувь нь эрэгтэй, 47.2 мянга буюу 43.6 хувь нь эмэгтэй байна.

Гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийг дагаж, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал, үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг баталж мөрдүүлэх, гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд төрийн байгууллага хяналт тавьдаг байхаар үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил, хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг магадлан итгэмжилж, хүүхэд гэр бүлтэй ажиллаж байгаа анхан шатны байгууллагуудаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүллээ.

Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах бүтэц, тогтолцоо, үйлчилгээний стандартыг бий болгон, амжилттай ажиллаж байна. Тухайлбал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар дундын хамтарсан баг, эцэг, эхийн зөвлөл байгуулагдаж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа жигдэрч, чадавхыг бэхжүүлсэн.

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр. Хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталж, Хүүхдийн төлөө сангийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Хүүхдийн төлөө сангийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж болон авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын орлогоос бүрдүүлэхээр тусгасан. Тус санд 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 1.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг батлан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Залуучуудын эрх, хөгжил, оролцооны чиглэлээр. Залуучуудын хөгжлийн төв бүх аймаг, дүүрэг, зарим сумдад ажиллаж, амьдрах ухаан, эрүүл мэнд, нөхөн үржихүйн сургалт, арга хэмжээнд 2020 онд нийт залуучуудын 24 хувийг хамрууллаа. Мөн зөвлөл, сонирхлын клуб, бүлгүүдийг тогтмол ажиллуулж, залуучууд нэгдэх, дуу хоолойгоо илэрхийлэх, эрх, ашиг сонирхолд нөлөөлөх аливаа төлөвлөлт, төсвийн хуваарилалтад санал тусгах боломжийг бүрдүүллээ.

Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах хүрээнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөг Залуучуудын хөгжлийн төвүүдээр хүргэхээс гадна Эрүүл мэндийн даатгалын талаарх оюутан, залуучуудын мэдлэг, ойлголт, хандлагыг сайжруулах арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлснээр их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад элсэн суралцагчдыг 100 хувь, бусад курсийн оюутан, суралцагчдын 80 хувь эрүүл мэндийн даатгалд хамрууллаа. Мөн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэгт оюутныг харьяалал харгалзахгүй хамруулж байна.

Зорилтот бүлгийн залуучуудын эрх, хөгжил, хамгааллыг дэмжих хүрээнд сэтгэл заслын зөвлөгөө үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын мэдээ мэдээлэл, ур чадварын сургалтад хорих ангид хоригдож буй залуучуудыг хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Мөн 18 насанд хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залуучуудын бие даан амьдрах чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ НЗДТГ, “НОСК” ХК-тай хамтран ажиллах санамж бичгийг байгуулав.

Ахмад настын хөгжил, хамгааллын чиглэлээр. “Ахмад настанд зориулсан сургалтын болон сурталчилгааны загвар хөтөлбөр”-ийг ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төслийн хүрээнд боловсруулж, батлан хэрэгжүүллээ.


Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох чиглэлээр 2020 оны жилийн эцсийн байдлаар 40-өөс дээш насны 78.7 мянган малчдыг сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээнд хамруулж, өмнөх оноос хамрагдалт 22 хувиар өссөн байна.

Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг хэрэгжүүлэх журам”, “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталж, хэрэгжүүлсэн нь ахмадуудын амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ахуй амьдралд нь эерэг нөлөө үзүүлсэн байна.

Эрүүл мэнд

2021 онд 19.9 мянган хүн нас барж, өмнөх оноос 4.0 мянга буюу 25.2 хувиар өссөн байна. 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 95 болж, өмнөх оноос 3.1 дахин өссөн.

Зураг 16. Нийт нас баралт болон эхийн эндэгдлийн харьцаа, жил бүрийн эцэст



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 онд 576.0 мянга болж, өмнөх оноос 17.2 дахин нэмэгдсэн бөгөөд нийт халдварт өвчнөөр өвчлөгчдийн 97.4 хувь буюу 561.2 мянга нь “Ковид-19”-өөр өвчлөгчид байна.

Хүснэгт 11. Халдварт өвчин, зарим өвчний төрлөөр, жил бүрийн эцэст, мянган хүн

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2021/2020
Халдварт өвчнөөр өвчлөгчид	42.1	45.2	33.4	576.0	17.2
Гар, хөл, амны өвчин	2.9	2.1	2.1	0.1	6.5
Цусан суулга	6.3	5.4	2.6	0.7	27.8
Тэмбүү	6.2	7.1	6.6	3.6	55.2
Гонококкт халдвар	5.5	5.8	5.1	3	59.2
Трихомониаз	4.5	5	4.4	2.7	60
Коронавируст халдвар	-	-	1.2	561.2	461.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2020 онд 49.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4 хувиар өссөн бол зардал 27 хувиар өсөж 62.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Орлогын 70 хувийг ажил олгогч даатгуулагчийн төлсөн шимтгэл, 28 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл, 1 хувийг өөрөө хариуцан даатгуулагчийн төлсөн шимтгэл тус тус бүрдүүлж байна. Зардлын 90 хувийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд, 3 хувийг сувиллын тусламж, үйлчилгээнд, 7 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулжээ.

Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2019.XII.1	2020.XII.1	Өсөлтийн хувь
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	46,998.9	49,108.3	4.4
Даатгуулагчийн төлсөн шимтгэл	739.8	719.3	-2.7
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	39,253.7	34,409.3	-12.3
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	7,005.4	13,979.7	99.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	49,082.6	62,364.1	27.0
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	40,350.9	55,964.1	38.7
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	1,564.7	2,177.0	39.1
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	7,167.0	4,223.0	-41.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсрол

Монгол Улс хүний хөгжлийн индексийн үзүүлэлтээр дэлхийн 189 улс орноос 99 дүгээр байранд орсон³ бөгөөд түүний бүрэлдэхүүн индекс болох хүн амын боловсролын түвшний индекс 2015 онд 0.732 байсан бол 2020 онд 0.761 болж 0.029 нэгжээр, дундаж наслалтын индекс 2015 онд 0.768 байсан бол 2020 онд 0.780 болж тус тус өссөн байна.


Боловсролын салбарын нийт төсвийн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 3.9 хувь болж, 0.7 нэгжээр буурсан бол улсын төсвийн орлогод эзлэх хувь 14.3 хувь болж, 2.6 нэгжээр буурчээ.

Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт төсөв 2020-2021 онд 1,738.1 тэрбум төгрөгөөс 2021 онд 1,737.2 тэрбум төгрөг болж, салбарын нийт төсөвт боловсролын салбарын төсвийн эзлэх хувь 97.5-95.9 хувь болж тус тус буурсан байна.

Монгол Улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин дэлхийн улс орнуудын дундаж түвшинтэй харьцуулахад өндөр хэвээр байна. Түүнчлэн хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор боловсролын үзүүлэлтүүд 2010 оны тооллогоос өсөж, харин 10, түүнээс дээш насны хүн амд боловсролгүй хүний эзлэх хувь буурсан байна.

³ Үндэсний статистикийн хороо, Хүний хөгжил-2020 тайлан, 2021 он


Зураг 17. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 1,453 байгууллагад 30,996 багш, ажилтан, 190,991 хүүхэд суралцаж, ерөнхий боловсролын сургалтын 839 байгууллагад 56,228 багш, ажилтан, 712,353 хүүхэд суралцаж, дээд боловсролын сургалтын 88 байгууллагад 12,175 багш, ажилтан ажиллаж, 148,954 оюутан суралцаж байна. Ингэснээр нийт хүн амын 31.3 хувь болох 1,052,298 хүн албан сургалтаар боловсрол эзэмших боломж бүрджээ.

Зураг 18. Боловсролын байгууллага, байршил, өмчийн хэлбэр



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилийн эхний байдлаар 1,453 цэцэрлэг, 848 ерөнхий боловсролын сургууль (ЕБС), 76 техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, 88 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 13. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, сургалтын байгууллагын төрлөөр

Сургалтын байгууллагын төрөл	Хичээлийн жилээр			
	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Цэцэрлэг	1,435	1,439	1,454	1,453
Төрийн	889	910	948	972
Хувийн	546	529	506	481
Ерөнхий боловсролын сургууль	803	820	839	848
Төрийн	656	662	672	682
Хувийн	147	158	167	166
Техникийн болон мэргэжлийн боловсрол, байгууллага сургалтын	86	80	75	76
Төрийн	51	50	46	43
Хувийн	35	30	29	33
Их, дээд сургууль, коллеж	94	95	88	88
Төрийн	18	21	20	20
Хувийн	76	74	68	68

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ковид-19 цар тахлаас үүдэн дэлхий даяар 6.5 сар буюу 26 долоо хоногийн хугацаатай хичээл тасарсан бөгөөд нийт суралцагчийн 2/3 нь буюу 1 тэрбум суралцагч сурлагын хоцрогдолтой байна⁴. Өөрөөр хэлбэл 91 хувь буюу 1.6 тэрбум суралцагч цар тахлын нөлөөнд өртсөн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд 2019-2020 оны хичээлийн жилд танхимаар хичээллэх нийт өдрийн 47 хувь, 2020-2021 оны хичээлийн жилд 63-68 хувийг тус тус зайн, цахим хэлбэрээр гэр бүлийн орчинд суралцсан. Хот, хөдөөгийн ялгаатай байдал, хөл хорио, цахим хичээлийн улмаас хагас жилийн хичээл тасалдаж, улмаар нийт суралцагчдын 70 орчим хувьд 3 сараас жил хүртэлх хугацааны хичээлийн хоцрогдол бий болжээ.

Урьдчилсан тооцооллоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдах насны хүн амын тооны өсөлтийг авч үзвэл, 2024 он гэхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо 230 мянга, ерөнхий боловсролын сургуульд хамрагдах хүүхдийн тоо 1,200 мянгад хүрэхээр байгаа нь сургууль, цэцэрлэгийн эрэлт өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 14. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдах насны хүн ам

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2023	2023	2024
Сургуулийн өмнөх боловсрол	185,476	179,979	174,746	173,346	176,588	189,373	209,196	233,491
Ерөнхий боловсролын сургууль (бага)	244,971	241,791	238,874	235,399	232,046	227,464	222,090	217,973
Ерөнхий боловсролын сургууль (дунд, ахлах)	983,235	1,011,671	1,045,224	1,084,158	1,122,778	1,159,943	1,194,013	1,218,544

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухаан, технологи

Монгол Улсад 2018 онд 59 байгууллагад 4,254 судлаач ажиллаж байсан бол 2020 оны статистик мэдээгээр 68 байгууллагад нийт 6,926 хүн ажиллаж байна.

⁴ Боловсрол, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО

Зураг 19. Шинжлэх ухааны байгууллагад ажиллагчид



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухаан, технологийн чиглэлээр 2020 онд үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм, шинжилгээний 68 байгууллагын 53 (77.9 хувь) нь төрийн өмчийн, 15 (22.1 хувь) нь хувийн өмчийн байгууллага байна. Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага 31 байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарт 2020 онд нийт 6,926 хүн ажиллаж байгаагаас 3,973 (57.4 хувь) нь эмэгтэй ажиллагчид байгаа ба нийт ажиллагчдын 6,109 (88.2 хувь) нь үндсэн, 5,033 (72.7 хувь) нь судлаачид, нийт судлаачдын 1,536 (30.5 хувь) нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Нийт ажиллагчдын дотор шинжлэх ухааны доктор 153, боловсролын доктор 1,697, академич 64, профессор 369, дэд профессор 564 байна.

Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тоо нэмэгдэж, 2020 онд 353 болжээ.


Зураг 20. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухаан, технологийн салбарын 33.3 хувийг шинжлэх ухааны, 21.8 хувийг нийгмийн шинжлэх ухаан, 20.8 хувийг байгалийн шинжлэх ухаан, 10.4 хувийг хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, 9.2 хувийг анагаахын шинжлэх ухаан, 4.5 хувийг хүмүүнлэгийн болон урлагийн шинжлэх ухаан тус тус эзэлж байна.

Зураг 21. Шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын бүтэц, эзлэх хувь



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухаан, технологийн чиглэлээр 2020 онд нийт 1,877 ажил хэрэгжсэнээс 1,008 (53.7 хувь) нь судалгаа хөгжүүлэлтийн ажил, 502 (26.7 хувь) нь судалгаа хөгжүүлэлтийн ажилд шууд хамааралгүй шинжлэх ухаан, технологийн үйлчилгээний ажил, 367 (19.6 хувь) нь шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа байна. Нийт судалгаа хөгжүүлэлтийн ажлыг төрлөөр нь авч үзвэл 69.3 хувь нь суурь судалгааны ажил байна.

Улсын төсвөөс 2020 онд нийт 353 судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлснээс 265 (75.1 хувь) нь суурь судалгааны ажил, 78 (22.1 хувь) нь хэрэглээний судалгааны ажил, 10 (2.8 хувь) нь туршилт, хөгжүүлэлтийн ажил байна. Түүнчлэн 2020 оны байдлаар 3 судалгаа тутмын 1 нь суурь судалгааны ажил байлаа.

Нийгмийн хамгаалал

Нийгмийн халамж: Улсын хэмжээнд нийт 12 төрлийн нийгмийн халамж, үйлчилгээний хөтөлбөр (тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ)-ийг хэрэгжүүлж байна.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулж байгаа хөрөнгө нь 2019 онд ДНБ-ий 1.1 хувь, хүүхдийн мөнгийг оруулж тооцвол ДНБ-ий 2.1 хувь, 2020 онд 4 хувьд хүрч бусад хөгжиж байгаа орнуудын нийгмийн халамжид зарцуулж байгаа дундаж зардалтай (ДНБ-ий 1.6 хувь) харьцуулахад харьцангуй өндөр байна.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд 2021 онд нийт 1,972.7 тэрбум төгрөгийг зарцуулснаас хүүхдийн мөнгийг оролцуулахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээнд 517.6 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 2018, 2019, 2020 онд үе шаттайгаар нэмэгдүүлснээр 2016 онтой харьцуулахад нийгмийн халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тусламжийн хэмжээ 34.3 хувиар, асаргааны тэтгэмжийн хэмжээ 32.0 хувиар, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмжийн хэмжээ 92.3 хувиар тус тус нэмэгдсэн.

Хүснэгт 15. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тэтгэвэр авагчдын тоо

Нийгмийн халамжийн сан	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020	2021	2022.III
Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэрт зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Тэрбум төгрөг	89.0	88.7	97.9	111.6	162.9	184.4	45.8
Тэтгэвэр авагчдын тоо	Хүн	71,293	61,769	59,437	62,640	60,359	74,571	55,690

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хүнсний эрхийн бичиг олгох арга хэмжээг нээлттэй, ил тод, тэгш хүртээмжтэй, сонголттой, хяналттай болгох зорилгоор 2021 онд “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг шинэчилсэн бөгөөд хамрагдах хугацааг 2 жил болгож, хөдөлмөрийн насны иргэнийг

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байх нөхцөлийг тавьж хэрэгжүүлж байна. Хэрэв 2 буюу түүнээс дээш удаагийн тохирсон ажлын байранд зуучлахад татгалзсан тохиолдолд дэмжлэгээс хасах, тухайн өрхийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагын мэдээллийн сантай тулгалт хийж, 200-аас дээш малтай өрх, 2-оос дээш орон сууцны байшин, 2-оос дээш бие даасан тохилог сууц, 2-оос дээш авто машинтай өрхийг хамруулах эсэхийг нягтлан шалгаж, хэрэв өөрчлөлт орсон нь тогтоогдвол тус үйлчилгээнээс хасахаар зохицуулсан. Ингэснээр 2021 онд нийт 15 аймгийн 26 сум, 3 дүүргийн 4 хороо хүнсний эрхийн бичиг авдаггүй болж, нийт 9 мянган өрхийн 50 гаруй мянган иргэн уг хөтөлбөрөөс хасагдаж, 2021 оны төсвөөс 2.6 тэрбум төгрөг хэмнэгджээ.

Нийгмийн даатгал. Нийгмийн даатгалд 2020 онд 953.3 мянган ажилтан албан журмын даатгалд, 193.1 мянган иргэн сайн дурын даатгалд, нийт 1,146.4 мянган иргэн, 2021 оны 12 дугаар сарын байдлаар 1,020.1 мянган ажилтан албан журмын даатгалд, 161.1 мянган иргэн сайн дурын даатгалд нийт 1,181.2 мянган иргэн тус тус хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 онд өмнөх оноос 27.7 хувиар, зарлага 5.4 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 16. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг

НДС	Орлого				Зарлага			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
Тэтгэвэр /+улсын төсөв/	1,734.3	2,071.1	1,594.5	2,058.1	1,619.3	1,839.2	2,174.9	2,332.6
Тэтгэмж	128.5	157.5	111.3	124.4	113.8	126.2	147.7	163.6
ҮОМШӨ	186.2	214.8	145.4	115.7	46.8	52.8	34.2	38.4
Ажилгүйдэл	41.1	41.5	25.9	26.5	34.7	44.0	94.9	59.7
Нийт	2,090.1	2,485.0	1,878.2	2,398.7	1,814.6	2,062.3	2,451.8	2,594.3

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нийгмийн даатгалын сангаас олгож буй хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 2020 онд өмнөх оноос 11.1 хувиар, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 13.0 орчим хувиар, дундаж тэтгэврийн хэмжээ 10.6 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 17. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, мянган төгрөг

	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ	216.0	216.0	243.0	270.0	300.0	300.0	400.0
Бүрэн тэтгэврийн доод хэмжээ	251.0	251.0	280.0	310.0	350.0	350.0	500.0
Дундаж тэтгэвэр	310.6	312.9	340.7	376.9	409.0	422.9	547.2

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас боловсруулан, УИХ-ын чуулганы 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлж байгаатай холбоотой хуулиар заасан нийт 27 дүрэм, журам, аргачлалыг боловсруулж батлуулах, хуулийг олон нийт, харьяа газар хэлтсийн нэгж, ажилтнуудад таниулж сурталчлах ажлууд хийж байна.

Монгол Улсаас гадаад улсад, гадаад улсаас Монгол Улс руу чиглэсэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шилжилт хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг үндэсний хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд тулгуурлан, нэгдмэл байдлаар зохицуулах зорилгоор Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын чуулганаар 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдан, 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжихээр болсон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2021 онд дараах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэв:

- “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-т нийт 19.3 мянган иргэн хамрагдаж 9.9 орчим тэрбум төгрөг зарцуулж, 13.4 мянган ажлын байр;
- “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т нийт 941 ахмад мэргэжилтэн хамрагдаж, 1.2 тэрбум төгрөг зарцуулж, 978 ажлын байр;
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т нийт 3.4 мянга гаруй иргэн хамрагдаж, 6.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 1,265 ажлын байр;
- “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т нийт 9.3 мянган иргэн хамрагдаж, 772.9 сая төгрөг зарцуулж 6.7 мянган иргэн ажлын байр;
- “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-т нийт 6.6 мянган иргэн хамрагдан, 497.9 сая төгрөгийг зарцуулж, 524 иргэн ажлын байр бий болсон.
- Төслийн үндсэн үйл ажиллагаа болох хөдөлмөрт бэлтгэх вакуумжсан багц сургалтыг 8 удаагийн ээлжээр амжилттай зохион байгуулж, нийт 2,389 залуучууд төсөлд хамрагдсан. Төсөлд хамрагдсан залуучуудаас 1,845 оролцогч залуучууд ажлын байран дээр дадлагажиж, үүнээс 726 залуу байнгын ажлын байраар тус тус хангагдсан.

Нийт хөтөлбөр, арга хэмжээнд 18.9 тэрбум төгрөгийг зарцуулж, 22,998 ажлын байр бий болсноос 4,665 байнгын, 11,868 түр, 6,465 цагийн ажлын байрыг бий болгосон.

Цалин

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт 205.0 мянган төрийн албан хаагчид ажиллаж байгаагаас төрийн улс төрийн албан тушаалтан 3,690 буюу нийт төрийн албан хаагчдын 1.8 хувь, төрийн захиргааны албанд 20.5 мянган албан хаагч буюу 10.0 хувь, төрийн тусгай албанд 45.5 мянган албан хаагч буюу 22.2 хувь, төрийн үйлчилгээний 135.3 мянган албан хаагч буюу 66.0 хувь тус тус байна.

Төрийн үйлчилгээний 135.3 мянган албан хаагчдын 58.1 хувь буюу 78.7 мянган албан хаагчид боловсролын салбарт, 22.4 хувь буюу 30.3 мянган албан хаагчид эрүүл мэндийн салбарт, 1.5 хувь буюу 2.0 мянга орчим албан хаагч шинжлэх ухааны салбарт, 4.5 хувь буюу 6.1 мянган албан хаагч соёл урлагийн салбарт, 13.5 хувь буюу 18.3 мянган албан хаагч төрийн үйлчилгээний бусад байгууллагад тус тус ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг 2018-2020 онд жил бүр 8 хувиар нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоож, цалингийн зэрэглэлийг ахиулах, төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох зэргээр цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын дундаж цалин 2014 оны түвшнээс 48.9 хувиар нэмэгдсэн. Үүнээс багш нарын цалин хөлс 45-58 хувиар, эмч, сувилагч нарын цалин хөлс 66-76 хувиар, соёл урлагийн салбарын ажилтнуудын цалин хөлс 38-48 хувиар, шинжлэх ухааны салбарын ажилтнуудын цалин хөлс 30-42 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалин хөлс 26-36 хувиар тус тус нэмэгдлээ.

Хүснэгт 18. Төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс, мянган төгрөг


Хариуцлагын хэлбэр	2018	2019	2020	2021.I
Улсын дундаж	1003	1124.3	1220.6	1314.9
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1110	1216.6	1279.8	1418.5
Төсөвт байгууллага	772.8	917.2	1053.4	1051.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 жилд 1 удаа хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, инфляцын түвшин, хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшинтэй уялдуулан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос 2 жилд 1 удаа тогтоохоор заасан. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 5 дугаар

тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс сард 320.0 мянган төгрөгөөр, 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс сард 420.0 мянган төгрөгөөр тус тус тогтоон мөрдөж байна.

Зураг 22. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, мянган төгрөг



Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ядуурал

Ядуурлын түвшин 2020 онд 27.8 хувь болж, 2018 оныхоос 0.6 нэгж хувиар буурч, нийт хүн амын 903.4 мянга нь ядуу амьдарч байна. Хот суурин газарт 2018-2020 онд ядуурлын түвшин 0.7, хөдөө орон нутагт 0.3 нэгж хувиар буурсан бөгөөд нийт ядуу хүн амын 64 хувь нь хот суурин газарт, үүнээс 43 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 23. Ядуурлын түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.4.БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж, эмзэг өртөмтгий Монгол Улсын хувьд олон улсын дэмжлэг туслалцаанд хамрагдах шаардлага өндөр байгааг анхаарч, Парисын хэлэлцээрийг 2016 онд УИХ-аар соёрхон батлуулсан. Уг конвенцын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, хөгжиж байгаа улс орнуудад санхүү, техник технологи, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх механизмууд бий болж байна.

Парисын хэлэлцээр 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба тус хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд Монгол Улс өмнө нь 2015 онд тодорхойлсон хүлэмжийн хийн ялгаралтыг 2030 он гэхэд 14 хувиар бууруулах зорилтоо ахиулан 22.7 хувь болгон тодорхойлж, Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ыг батлуулан хэрэгжүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дулааны улирлын хур тунадасны хэмжээ ихээхэн буурч хуурайших, гандуу болох, цөлжих, газрын доройтол нэмэгдэх, хөрс үржил шимээ алдах явц илүү эрчимжих болсон. 2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай бүхий газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна.

Хүснэгт 19. Цөлжилтийн үйл явцын хандлага, хувь

Цөлжилтийн үнэлгээ хийсэн он	Сул илэрсэн нутаг	Дунд зэрэг илэрсэн нутаг	Хүчтэй илэрсэн нутаг	Нэн хүчтэй илэрсэн нутаг	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
2006 он	23.0	26.0	18.0	5.0	72.0
2010 он	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015 он	24.1	29.8	16.8	6.1	76.8
2020 он	31.5	22.1	18.6	4.7	76.9

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрч байгаа нь цөлжилтийн үндсэн шалтгааны нэг болсон байна. Уул уурхай эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой эвдэрсэн газрын тоо хэмжээ 30 мянга орчим га талбай болж олон жил орхигдсон 8.0 мянган га талбайг ирэх 4 жилд нөхөн сэргээх шаардлагатай байна.

Хот суурин газрын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын ариун цэврийн байгууламжаас гадна хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдол зэргээс үүдэлтэй байна.

Ус. Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог бөгөөд 2021 онд Монгол Улсын гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн 49.9 хувь нь улсын тусгай хамгаалалтад байна. Нийт 564.8 тэрбум шоо метр нөөцтэйгөөс 10.5 тэрбум шоо метрийг ашиглах боломжит нөөцтэй гэж үздэг. Гэвч энэхүү усны нөөцийн дийлэнх буюу 80 орчим хувь нь нутаг дэвсгэрийн 30 хувьд буюу хангайн бүсэд, томоохон голуудын хөндийд бүрэлдэн бий болдог.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хур тунадасны хэмжээнээс хамаарч сүүлийн жилүүдэд гол, горхи, нуур, цөөрөм ширгэж байна. Усны 2019 оны тооллогын дүнгээр 264 гол горхи, 704 булаг шанд, 286 нуур тойром ширгэсэн судалгаа гарсан.

Нийтийн аж ахуйн салбарт 2021 онд тусгай зөвшөөрөл бүхий 140 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж, хоногт дунджаар 550 гаруй мянган метр куб цэвэр усыг олборлон хүн ам, үйлдвэр аж ахуйн газрын унд ахуйн хэрэгцээнд түгээж, хэрэглээнээс гарсан 400 гаруй мянган метр бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үйлчилгээ үзүүлж байна.

Улсын хэмжээнд ахуйн бохир ус цэвэрлэдэг 86, үйлдвэрийн бохир усыг цэвэрлэдэг 29, нийт 117 цэвэрлэх байгууламжтай. Үүнээс 21 аймгийн 62 сумын төвийн цэвэрлэх байгууламж биологийн цэвэрлэгээ хийж байна. Нийслэл Улаанбаатар хотын 5 дүүрэгт 9

цэвэрлэх байгууламж ажилладаг. Нийт цэвэрлэх байгууламжуудаас 10 нь цэвэршүүлэн гарч буй бохир усыг голд шууд хаяж, 61 нь хөрсөнд шингээн зайлуулдаг.

Улсын хэмжээнд хоногт 400 мянган метр куб бохир усыг цэвэршүүлэн байгальд нийлүүлж байгаа ч 136 мянган метр куб бохир усыг механик болон биологийн цэвэрлэгээ хийхгүйгээр байгальд шууд нийлүүлдэг. Улаанбаатар хотын гэр хороололд 310 гаруй мянган нүхэн жорлон, 140 гаруй мянган угаадасны нүх ашиглаж байгаагаас үүдэн хөрс, ус их хэмжээгээр бохирдож байна.

Агаарын бохирдол. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж 2021 онд өмнөх оноос PM2.5 тоосонцор 13 мкг/м³-ээр буюу 25 хувиар, PM10 тоосонцор 32 мкг/м³-ээр буюу 33 хувиар, азотын давхар исэл 17 мкг/м³-ээр буюу 45 хувиар, хүхэрлэг хий 11 мкг/м³-ээр буюу 14 хувиар тус тус ихэссэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоос харахад 2021 онд 196.0 мянган зуух тоологдож 12.8 хувиар, гэр хороололд 6,510 байнгын, 20.0 мянган түр оршин суух айл өрх шинээр тус тус нэмэгдсэн байна. Мөн нийт 1,216 мянган авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас Улаанбаатар хотод 53.6 хувь нь буюу 661.4 мянган хөдөлгөөнт эх үүсвэр бүртгэгдсэн байна.

Түүнчлэн нийт 20 аж ахуйн нэгж, байгууллагын 182 зуух 130.0 мянган тонн түүхий нүүрс хэрэглэж байгаагаас технологийн зориулалтаар уур үйлдвэрлэгч 68 аж ахуйн нэгж, байгууллагын 88 уурын зуух 68.0 мянган тонн мидлинг хэрэглэж байна.

Ойн сан. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн 84.9 хувийг нутгийн хойд хэсэгт тархах шилмүүст, навчит ой, 15.1 хувийг нутгийн өмнөд хэсгийн говь, цөлийн бүсэд тархах Заган ой эзэлж байна. Хэдийгээр нийт газар нутагт эзлэх ойн талбайн хэмжээгээр бага боловч 1 хүнд ногдох ойн талбай 4.09 га байгаа нь дэлхийн дундаж 0.54 га үзүүлэлтээс өндөр үзүүлэлт юм. Ойн сангийн талбай 18.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж байгаагаас 12.4 мянган га нь ойгоор бүрхэгдсэн (байгалийн болон таримал ой, гол мөрний дагуух бургас, сөөг), 5.6 мянган га нь ойгоор бүрхэгдээгүй (тармаг мод, байгалийн аясаар ойжиж байгаа болон зориудаар ойжуулж байгаа газар, түймэр, мод бэлтгэл, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ой), 521.6 мянган га нь ойн сан доторх ойн бус талбайд хамаардаг байна. Ойн сангийн 15.4 сая.га буюу 83.1 хувь нь хамгаалалтын бүсийн, 3.1 сая мянган га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна.

Монгол оронд 8 баг 62 овог, 316 төрөлд хамаарах 737 зүйлийн шавж нь мод, бут, сөөгийн навч шилмүүс, иш холтос, модлог, үр жимс, үндсээр хооллон ойд их, бага ямар нэг хэмжээгээр хөнөөл учруулдаг тул жил бүр урьдчилан сэргийлэх болон тэмцлийн ажлыг гүйцэтгэж байна.

Хүснэгт 20. Ойн нөхөн сэргээх ажил

Арга хэмжээ	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Үр бэлтгэх талбай, га	50.0	-	50.0	50.0	20.0	20.0	-
Үрийн нөөц, кг	612.0	477.0	460.0	314.0	175.5	64.5	330.0
Тарьц, сая.шир	46.3	30.0	34.6	34.6	38.9	41.6	14.6
Ойжуулалт, га	5,240.0	3,163.0	2,381.6	3,221.8	2,392.5	3,088.7	2,967.0
Ойн зурвас, га	392.7	172.0	223.5	345.9	1,878.1	371.5	310.0
Байгалийн сэргэн ургалтад туслах, га	85.0	100.0	1,067.0	2459.9	4683.5	582.0	1,647.0
Нийт	5,717.7	3,435.0	3,672.1	6,027.6	8,954.1	4,042.2	4,924.0

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

1.5.ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

Эрх зүйн шинэчлэл

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төсөл, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль /Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн өргөн мэдүүлээд байна.

Цагдаагийн байгууллага. Цагдаагийн байгууллагын хөгжлийг дунд хугацаагаар тодорхойлон, Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор батлуулж, цагдаагийн байгууллагад хийгдсэн шинэчлэлийн үр нөлөөг гүнзгийрүүлэх, үйл ажиллагаандаа өндөр технологийг нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангах, мэргэшсэн, чадварлаг, харилцааны өндөр соёлтой хүний нөөцөөр бэхжүүлсэн бүрэлдэхүүнээр ард иргэдийнхээ аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангах, шуурхай, найдвартай ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 10,986 алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд нийт 25,429, нийслэлд 16,534, орон нутагт 8,880, бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ 15 гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад нийт хэрэг 2,365 буюу 10.3, нийслэлийн хэмжээнд 1,901 буюу 13.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 460 хэрэг буюу 5.5 хувиар, бусад газар 4 буюу 36.4 хувиар тус тус өссөн.

Улсын хэмжээнд нийт 2,074.4 мянган зөрчил шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 202.4 мянган зөрчил буюу 8.9 хувиар, үүнээс 2,069.9 мянган зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 202.4 мянга буюу 8.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүх нийтийн бэлэн байдлын хугацаанд цагдаагийн байгууллага нь тэргүүн шугамд ажиллаж Ковид-19 халдвар тээгч болон хавьтлыг олж тогтоох, газар, орныг бүслэн хаах, тусгаарлах байр, эмнэлгийн бүс, гудамж, зам талбайг хамгаалалтад авч, хөл хорионы дэглэмийг сахиулах, иргэд, олон нийтэд ухуулга сурталчилгаа явуулах ажил, арга хэмжээг шуурхай гүйцэтгэж ажилласан.

Хил хамгаалах байгууллага. Монгол Улс нь 8,252.6 км урт хилийн шугамтайгаас 7,351.6 км хуурай газрын, 901.058 км усан хилтэй. ОХУ-тай 3,543 км, БНХАУ-тай 4,709.6 км хэсгээр хиллэдэг.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийг хоёр улсын хооронд 1958, 1976 онд байгуулсан хилийн гэрээнүүдийн дагуу газар дээр нь тогтоон тэмдэглэсэн. Хилийн дэглэмийн гэрээг 1980 онд байгуулж, 2006 онд шинэчлэн, хамтарсан шалгалтыг 1987-2001 онд зохион байгуулсан.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн гэрээг анх 1962 онд байгуулж, 1988 оны хилийн дэглэмийн гэрээг 2010 онд шинэчлэн, хамтарсан шалгалтыг 1982-1984 онд, 2001-2004 онд 2 удаа зохион байгуулсан.

Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгсэл 2021 онд өмнөх онтой харьцуулахад зорчигч 51.1 хувиар, тээврийн хэрэгсэл 26.6 хувиар тус тус буурсан.

Хилийн зөрчлийн илрүүлэлт 98.0 хувьтай, шийдвэрлэлт 99.1 хувьтай, өмнөх онтой харьцуулахад хилийн зөрчлийн илрүүлэлт 2.0 хувиар буурч, шийдвэрлэлт 3.5 хувиар өссөн. Хил орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт 100.0 хувьтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Монгол Улсын хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд чиглэл хариуцсан алба 3, хорих анги 18, хорих анги бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 7, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 18, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс 6, бусад салбар нэгж 9 зэрэг нийт 61 алба, анги, байгууллага, газар, хэлтэс, салбар нэгжид офицер 1,569, ахлагч 1,490, энгийн 118, нийт 3,177 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хаалттай тусгай нэгж 1, хаалттай дэглэмтэй хорих анги 5, нээлттэй, хаалттай дэглэмтэй хорих анги 8, нээлттэй дэглэмтэй хорих анги сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 1, төрөлжсөн эмнэлэг 1, нэгдсэн эмнэлэг 1, нийт 21 хорих ангид хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хорих байгууллага, цагдан хорих байрны харуул хамгаалалтын өдөр тутмын үйл ажиллагаанд “Хэт богино долгион”-ы аналог радиохолбооны техник хэрэгсэл ашиглан мэдээ, мэдээллийг түргэн шуурхай солилцож хоригдол, хоригдогч, алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар. Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд 21 аймаг, 9 дүүрэг, 330 сум суурин, 171 хороо бүрэн холбогдсон.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал “www.e-mongolia.mn” системд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 22 төрлийн лавлагаа, 37 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn системээр дамжуулан үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан шаардлагатай цаасан нотлох баримт бичгийг шуудангаар хүлээн авч, бүртгэгдсэн бичиг баримтыг буцаан хүргүүлэх зорилгоор нэг талт болон хоёр талт шуудангийн үйлчилгээг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, “Монгол шуудан” ХК-тай хамтран нэвтрүүлсэн бөгөөд улсын бүртгэлийн цахим гэрчилгээг үйлчилгээнд нэвтрүүлсэн.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал “www.e-mongolia.mn” системээр дамжуулан хуулийн этгээд үүсгэн байгуулах боломжтой болсон. Энэ ажлын хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 10 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн бөгөөд нийт 380 цахим гэрчилгээ олгосон ба 2022 онд 57 төрлийн үйлчилгээг нэмэлтээр цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна.

Гадаадын иргэн, харьяатын газар. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдсон асуудал, гадаадын иргэний гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, Олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олголт, бүртгэл, хяналтын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, хөтлөх зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.

Архивын Ерөнхий газар. Үндэсний төв архив болон аймаг, нийслэлийн төрийн архивууд иргэн, хуулийн этгээдээс орон зай, байршлаас хамааралгүйгээр лавлагааны захиалга хүлээн авах, хариуг тоон гарын үсгээр баталгаажуулан төрийн архив болон байгууллага хооронд солилцох боломжтой “Төрийн архивын үйлчилгээний нэгдсэн систем”-ийг төрийн 23 архивын лавлагаа, үйлчилгээнд нэвтрүүлж, тус системээр лавлагааны захиалга хүлээн авч, үүнээс 3,018 лавлагааг шийдвэрлэсэн. Мөн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-Mongolia”-д архивын 5 төрлийн лавлагаа, үйлчилгээг холбосон. Төрийн 23 архивд үүссэн архивын мэдээллийн санг нэгтгэх ажлын төлөвлөгөөний дагуу 21 төрийн архивын 5,514 хөмрөгийн 8,185 данс, бүртгэлийн

338,603 хадгаламжийн нэгжийн 11,969 баримтын мэдээллийг “Төрийн архивын нэгдсэн систем”-д хөрвүүлсэн.

Гадаад харилцаа

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад харилцааны чиглэлээр тусгагдсан арга хэмжээг улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалах чиг шугамаа тууштай баримталж, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлж, улс орны хөгжлийн гадаад таатай нөхцөлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Олон улстай харилцаагаа бэхжүүлэх хүрээнд НҮБ-ын бүх гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоох чиглэлийг баримталж, 2021 онд 1 улстай дипломат харилцаа тогтоосноор манай улсын дипломат харилцаатай улсын тоо 193-т хүрлээ. Эдгээр орнуудтай болон олон улсын байгууллагуудтай хоёр талын хийгээд олон талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна.

Хөрш орнуудын харилцаа. ОХУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн харилцааг шат ахиулах, БНХАУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, чингэхдээ хамтын ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн зорилт тавин ажилласан бөгөөд үүнээс дурдвал:

- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 12 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийж, Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан тунхаглал гаргаж, Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр байгуулахаар тохиролцсон. Мөн Засгийн газар болон салбарын байгууллага хоорондын хамтын ажиллагааны Хилийн боомт болон Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах протокол, Хилийн Боршоо-Хандгайт, Ханх-Монд боомтыг олон улсын зэрэглэлд шилжүүлэх, Хилийн зарим боомтыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, нислэгийн тоог нэмэх, нислэгийн шинэ маршрут гаргах, Ази, Европыг холбосон тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэхтэй холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг, ОХУ-д суралцах оюутны квотыг нэмэх, хамтарсан сургууль байгуулах, эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр яам хооронд 2021-2023 онд хамтрах хөтөлбөр батлах, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийг шинэчлэх, шинэ коридор бий болгох, тээвэр, логистикийн хамтын ажиллагааг хөгжүүлэх санамж бичиг байгуулах, Гаалийн хяналт, оюуны өмч, соёл урлагийн салбарт хамтрах зэрэг 8 баримт бичигт гарын үсэг зурж, ирээдүйд чиглэсэн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, хоёр талын харилцааг эдийн засгийн бодит агуулгаар баяжуулах чиглэлээр хоёр тал санал солилцсон.
- Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2021 оны 9 дүгээр сард Вена хотод болсон Дэлхийн парламентын дарга нарын V дугаар бага хуралд оролцох үеэр ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.И.Косачёвтай уулзалт хийсэн.
- Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2021 оны 5 дугаар сарын 30-наас 6 дугаар сарын 5-ны өдрүүдэд ОХУ-д ажлын айлчлах үеэр ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтай албан ёсны хэлэлцээ хийж, Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалт болон Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулсан зарим арга хэмжээнд оролцсон.
- Монгол Улс, ОХУ-ын Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг ОХУ-аас Монгол Улсад суух Элчин сайдын яам, “Монгол-Орос” найрамдлын

нийгэмлэг, Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвтэй хамтран тэмдэглэлээ.

- “Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг дэмжих тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх “Монгол, Оросын бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг 2021-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2021 оны 3 дугаар сард байгуулсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдөр утсаар ярьж, байгаль орчны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, цөлжилт, шороон шуургатай тэмцэх төслийг хамтран хэрэгжүүлэхээр санал нэгдэж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын Байнгын хорооны дарга Ли Жанышутай 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр цахим уулзалт хийж, Монгол, Хятадын парламентын байнгын уулзалтын механизмын 4 дэх удаагийн хуралдааныг цахим хэлбэрээр 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр болсон “Азийн төлөөх Боаогийн чуулга уулзалт”-ын 2021 оны жилийн уулзалтын нээлтийн ажиллагаанд цахим хэлбэрээр оролцож, үг хэлэв.
- Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, “Цар тахалтай тэмцэх хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл”-ийг гаргав. БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд Вэй Фөнхө 2021 оны 7 дугаар сарын 26-ны манай улсад айлчилсан. Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ-д хоорондын Стратегийн яриа хэлэлцээний 6 дахь удаагийн уулзалтыг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, талууд хоёр улсын харилцааны хөгжлийн явцыг дүгнэж, ойрын хугацааны зорилт, томоохон арга хэмжээний талаар ярилцахын зэрэгцээ бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон.
- Хятадын талтай бүх түвшинд байнгын хэлхээ холбоотой ажилласны дүнд Ковид-19 цар тахлын үеийн хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, ялангуяа экспорт, импортын урсгалыг тасалдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, Тяньжин боомтод чингэлэгтэй ачаа бөөгнөрсөн асуудлыг шийдвэрлэсэн.
- Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын Гадаад хэргийн яамнаас “Цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны механизм” байгуулан 3 удаа хуралдаж, “Ногоон гарц” түр журмын хэрэгжилт, иргэд хоорондын солилцоог нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, цар тахлын нөхцөл байдал, тархалтыг хязгаарлах чиглэлээр авч буй арга хэмжээ, Монгол Улсын бүтээн байгуулалтад оролцох ажиллах хүчийг шуурхай нэвтрүүлэх зэрэг асуудлаар санал солилцсон.
- БНХАУ-ын Засгийн газраас манай улсын цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс 2021 онд 300.0 мянган тун вакцин болон 3 удаа нийт 28.0 сая юанийн буцалтгүй тусламжаар халдвар хамгааллын хэрэгсэл, шинжилгээний тоног төхөөрөмж зэрэг бараа бүтээгдэхүүний тусламж үзүүллээ.

Гуравдагч хөршийн харилцаа. Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2021 оны 9 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд АНУ-д айлчилж, тус улсын төр засгийн төлөөлөл, Конгрессын зарим гишүүнтэй хоёр талын уулзалт хийхийн зэрэгцээ Конгресс дэх Байгаль орчныг хамгаалах бүлгийн жилийн арга хэмжээнд урилгаар оролцсон нь хамтын ажиллагааг байгаль орчныг хамгаалах чиглэлээр өргөжүүлэхэд чухал түлхэц боллоо.

- Монгол, Америкийн Стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай тогтоолыг АНУ-ын Конгрессын Сенатын танхим 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталсан.
- АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-тай 2018 онд байгуулсан 350.0 сая ам.долларын Хоёр дахь компакт гэрээ 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд тус гэрээний дагуу баригдах ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн шав тавих ёслол 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр болсон.
- АНУ-ын зүгээс КОВАКС-ын шугамаар хоёр удаагийн хүргэлтээр нийт 1,088,100 тун Файзер компанийн вакцин Монгол Улсад нийлүүлсэн бөгөөд тус улсаас манай

улсад хамгаалалтын хэрэгсэл, амьсгалын аппарат, амьсгалын аппаратыг ашиглах сургалтын зориулалт бүхий уушги орлуулагч зэрэг нийт 7.0 сая гаруй ам.долларын тусламж үзүүлсэн.

- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 7 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Токиогийн зуны XXXII Олимпын наадмын нээлтийн ажиллагаанд оролцох хүрээнд ажлын айлчлал хийж, энэ үеэрээ Япон Улсын Цог жавхлантай Эзэн Хаан Нарүхито-д бараалхаж, Ерөнхий сайд Ё.Сүгатай албан ёсны уулзалт хийж, Монгол, Японы Стратегийн түншлэлийг 2017-2021 онд хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөр амжилттай хэрэгжиж дуусгавар болж буйг хоёр тал сайшааж, ирэх 4 жилд хэрэгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийг тохирох талаар нягт хамтран ажиллахаар тогтсон. Япон Улсын Засгийн газраас НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-гаар дамжуулан Ковид-19 цар тахалтай тэмцэхэд болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 21.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгосон.
- Монгол Улсын Засгийн газар, Европын Комисстой төсвийн дэмжлэгийн санхүүжилтийн хэлэлцээр анх удаа байгуулж, Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт 2020-2024 оны хооронд 50.8 сая еврогийн буцалтгүй тусламж олгох болсон. Европын Холбоо манай улсыг 2021–2027 оны хөгжлийн тусламжийн Олон жилийн баримжаат хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулах шийдвэрийг 2021 онд гаргаж, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтвортой ногоон хөгжил, ардчилал, эдийн засгийн хөгжил хэмээн тодорхойлсон нь манай улсын хөгжлийн зорилттой бүрэн нийцэж байна.
- Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр Бүгд Найрамдах Энэтхэг Улс манай улсад анхны 150.0 мянган тун Астразенека компанийн “Ковишийлд” вакциныг буцалтгүй тусламжаар 2021 оны 2 дугаар сард олгож, “Ковид-19” эмчилгээний зориулалттай “Ремдесивир” тариа 200.0 мянган тунг нийлүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад тус улсын зүгээс дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас БНЭУ-д Ковид-19 цар тахал хурдацтай тархаж буйтай холбогдуулан 1.0 сая ам.долларын хүмүүнлэгийн тусламж олгов.
- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр цахим уулзалт хийж, хоёр улсын харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүрснийг тунхаглан зарлаж, Хамтарсан тунхаглал гаргав. Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 2021 онд цар тахалтай тэмцэхэд зориулан Монгол Улсад 1.5 сая ам.доллар бүхий буцалтгүй тусламж үзүүлж, Солонгосын “Segeene” компаниас 500.0 мянган ам.доллар бүхий тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн яаманд, БНСУ-ын “Халдварт өвчнийг хянах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээрх Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны санаачилга”-ын хүрээнд “SD Biosensor” компанийн үйлдвэрлэсэн 300.0 мянган ам.долларын үнэ бүхий 71,250 ширхэг эсрэг биет манай улсад хандивласан.

Олон талт хамтын ажиллагаа. Монгол Улс НҮБ болон олон улсын байгууллагын хүрээнд 2019-2023 онд НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай конвенцын Засгийн газар хоорондын хорооны гишүүн, 2020-2022 онд Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын гишүүн, 2019-2022 онд НҮБ-ын АНДЭЗНК-ын Ази, Номхон далайн статистикийн хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн, 2019-2022 онд Ази, Номхон далайн гамшгийн мэдээллийн удирдлагыг хөгжүүлэх төвийн Удирдах зөвлөл, Олон улсын атомын энергийн агентлагийн Захирагчдын зөвлөлийн гишүүн, ЮНЕСКО-гийн Нийгмийн өөрчлөлтийн удирдлагын хөтөлбөрийн Зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 9 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо ажиллаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлийн 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанд үг хэлж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын тоог 15 хувьд хүргэх зорилт тавьж, энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын оролцооны асуудлаарх олон улсын бага

хурлыг 2022 онд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар төлөвлөснийг мэдээлж, 2030 он гэхэд Монголд тэрбумаар тоологдох хэмжээний мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж эхэлснийг танилцууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ИБУИНХУ-ын Глазгоу хотноо 2021 оны 11 дүгээр сарын 1-2-ны өдрүүдэд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцож, хэлсэн үгэндээ Монгол Улс хүлэмжийн хийг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн улс орнуудын хүч чармайлтыг бүрэн дэмжиж, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхийн төлөө дайчлан ажиллахыг нотлон, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулахаар ахиулан тодорхойлсныг мэдэгдэж, ойн хомстол, газрын доройтлыг бууруулах хамтын хүч чармайлтад уриалсан “Глазгоугийн удирдагчдын тунхаглал”-д манай улс нэгдэн орлоо.

Худалдаа эдийн засгийн харилцаа. Хөрш орнууд болон голлох түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монголын экспортын бараа бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөтгөх, худалдааг хөнгөвчлөх асуудалд анхаарч ажилласан. “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг урагшлуулах хүрээнд “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн шинжээчдийн түвшний V хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжих хугацааг дахин таван жилээр сунгах, төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх, “Цайны их зам” хил дамнасан аялал жуулчлалын маршрутын Замын зураглалын төслийг тохиролцох ажлыг эрчимжүүлэхээр тохиролцож, гурван улсын төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтыг зохион байгуулахад хамтран ажиллахаар тохиролцлоо.

Иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх. Консулын албыг бэхжүүлэх хүрээнд АНУ-ын Чикаго хотод Консулын газар нээн ажиллуулах шийдвэрийг Улсын Их Хурлын 2021 оны 64 дүгээр тогтоолоор батлуулж, үйл ажиллагааг 2022 оны 3 дугаар сард эхлүүлсэн.

- Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан тогтоосон хилийн хязгаарлалтаас агаарын хил нээгдэх хүртэлх хугацаанд буюу 2020 оны 2 дугаар сарын 1-ээс 2021 оны 6 дугаар сарын 1-ний хооронд дэлхийн 93 улсаас Монгол Улсын нийт 36360 иргэнийг зохион байгуулалттайгаар татан авсан. Нислэгийн тоо, давтамжийг нэмэгдүүлэх, нислэгийн тийзийн үнийг бууруулахад ахиц гаргаж, 2021 оны 6 дугаар сараас эхлэн сард 18-36 нислэг, 10 дугаар сараас сард 50-60 нислэг үйлдсэн байна. Цар тахалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэн бүрд олгосон 300.0 мянган төгрөгийн тусламжийг хилийн чанадад байгаа Монгол Улсад банкны дансгүй 88.0 орчим мянган иргэнд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулсан.
- Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах зорилтын хүрээнд Монгол Улсын цахим визийн системийг 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс амжилттай нэвтрүүлж, гадаадын 36 улсын иргэдэд богино хугацааны 3 ангиллын визийг цахимаар олгож эхэлсэн. Монгол Улсын цахим визийн загварыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага, гадаадын улс орнуудад дипломат шугамаар мэдэгдсэн бөгөөд тус системээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гадаадын 94 иргэн виз мэдүүлснээс 88 иргэнд зохих ангиллын визийг олголоо.
- Хилийн чанадад үзүүлэх консулын үйлчилгээний хураамжийг боловсронгуй болгох, жигд тогтоох ажлыг эрчимжүүлж, Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн “Улсын тэмдэгтийн хувь хэмжээ, үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 195 дугаар тогтоолоор батлуулсныг нийт ДТГ-ууд хүчин төгөлдөр мөрдөж байна.
- Консулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 2021 онд иргэдэд мэдээлэл түгээх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй идэвхтэй хамтран ажилласны зэрэгцээ www.consul.mn цахим хуудсанд 155 мэдээ, сэрэмжлүүлгийг байршуулж, гадаад улсыг зорьж буй монгол иргэдэд

шаардлагатай мэдээ, мэдээллийг хүргэх үндсэн суваг болгон ашигласнаар 710.0 мянга хүн хандсан байна.

Олон улсын гэрээ, эрх зүйн харилцаа. 2021 онд манай улс олон талт Дэлхийн шуудан холбооны дүрмийн 10 дугаар нэмэлт протокол, Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн улсууд хоорондын конвенц, Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын дүрэм, Олон улсын эрүүгийн шүүхийн дархан эрх, эрх ямбаны тухай хэлэлцээр, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын аяллын цахим баримт бичгийн Нийтийн түлхүүрийн мэдээллийн сан, Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ зэрэг 6 гэрээнд нэгдэн орох дотоодын процедурыг хангаж, Засгийн газар хоорондын 10 гэрээ байгуулснаас 7 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бол өмнөх онд байгуулсан 11 гэрээг хүчин төгөлдөр болгосон. Түүнчлэн байгууллага хоорондын 20 гэрээ байгуулж бүртгэсэн бол гэрээний төсөлд санал өгөх, орчуулгыг хянах зэрэг байгууллага хоорондын нийт 96 гэрээ байгуулахтай холбоотой үйл явцад оролцсон.

Батлан хамгаалах

Батлан хамгаалах салбар нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцсэн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, улс орны хөгжлийн зорилго, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэн, мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлэх үндсэн зорилго тавьж ажиллав.

Мөн тайван цагийн бусад чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас гаргасан тогтоол, зарлиг, зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлуудад Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцож байна.

Эрх зүйн орчны шинэчлэл. Батлан хамгаалах салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичгийг улам боловсронгуй болгож, салбарын хөгжлийг хангах үүднээс 2021 онд Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулж “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хийсэн.

Түүнчлэн Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн ээлжит хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 41 дүгээр тогтоолоор Цэргийн дүйцүүлэх албыг 2021 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, 2021 оны 220 дугаар тогтоолоор Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн орон тооны дээд хязгаарыг баталсан.

Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх. Зэвсэгт хүчний бүтцэд 2021 онд Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар байгуулагдаж, бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын 2021 оны 19 дүгээр хуралдаанд танилцуулж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Зэвсэгт хүчний эрх зүйн орчин шинэчлэгдэн, тайван цагийн бүтэц, орон тооны хүч хэрэгслээрээ хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх анги, салбар нэмэгдэж, тэдгээрийн бэлэн байдал, чадавхын

түвшин дээшилж, цаашид мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлнэ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын барилга, Тавантолгой түлш ТӨҮГ-ын түүхий эдийг тээвэрлэх, Хөвсгөл нуурын байгаль экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, Замын-Үүд боомтын ачаа эргэлтийг нэмэгдүүлэх зэрэг стратегийн бүтээн байгуулалтад болон улс орон, нийслэл хотын өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэлээ.

ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, БНПУ, Япон Улсаас нийт 68.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 10 гаруй нэр төрлийн зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг гэрээ, хэлэлцээрийн хүрээнд болон буцалтгүй тусламжаар авч зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэн сайжруулах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахаар бэлтгэж буй салбар, нэгжийн техник, хэрэгслийн нөхөн хангалтыг бүрдүүлсэн.

Батлан хамгаалахын гадаад харилцаа, энхийг дэмжих ажиллагаа. Монгол Улсын аюулгүй байдлыг цэрэг-улс төр, дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, өнөөдрийн байдлаар 37 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байгаагаас ОХУ, БНХАУ, Украин, Беларусь, Турк зэрэг улсуудтай цэрэг-техникийн хамтын ажиллагаатай байна.

Энхийг дэмжих ажиллагааны хүрээнд 2021 онд БНӨСУ, Абей муж, Баруун Сахар, БНАКУ, Йемэн зэрэг 5 улсын нутаг дэвсгэрт явагдаж буй ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс нийт 883 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүллээ.

Цаашид Монгол Улсын зэвсэгт хүчнээс энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Түргэн байрлах хүчний рот”, “Инженерийн рот”, “Цэргийн хээрийн II шатны эмнэлэг”-ийн үндсэн болон өөрийгөө хангах техник, тоног төхөөрөмж, бэлэн байдал, сургалтын түвшнийг НҮБ-ын “Үнэлгээ зөвлөмжийн үзлэг”-т 2021 оны 10 дугаар сард цахим хэлбэрээр амжилттай шалгуулж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чадавхын бэлэн байдлын системийн 2 дугаар түвшинд гаргасан.

Монгол Улсын зэвсэгт хүчин нь 20 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон эвслийн цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 20.0 мянга гаруй цэргийн албан хаагч оролцож, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулаад байна.


1.6. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

Дэлхийн эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл

Дэлхий нийтээр сүүлийн хоёр жилийн хугацаанд Ковид-19 халдвараас үүдэлтэй эрүүл мэнд болон эдийн засгийн хүндхэн сорилтуудтай нүүр туллаа. Дэлхий дахинд цар тахлын сөрөг нөлөө намжаагүй байгаа энэ үед дэлхийн олон оронд инфляц зорилтот түвшнээс давж, ОХУ-Украины нөхцөл байдал хурцадсан нь үнийн өсөлт, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдлаар дамжин дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Олон Улсын Валютын Сан энэ оны 4 дүгээр сард нийтэлсэн тайландаа 2022 болон 2023 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.6 хувь болгож, өмнөх төсөөллөөс 0.8 болон 0.2 нэгж хувиар тус тус бууруулаад байна.

Зураг 24. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаг, хувиар

Хүснэгт 21. Улс орнуудын эдийн засгийн өсөлт, хувиар



	2021	2022	2023
ДЭЛХИЙ	6.1	3.6	3.6
Хөгжингүй орнууд	5.2	3.3	2.4
АНУ	5.7	3.7	2.3
Евро бүс	5.3	2.8	2.3
Япон	1.6	2.4	2.3
Хөгжиж буй орнууд	6.8	3.8	4.4
БНХАУ	8.1	4.4	5.1
ОХУ	4.7	-8.5	-2.3

Эх сурвалж: ОУВС-гийн 2022 оны 4 дүгээр сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлан

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын энэ оны 3 дугаар сард нийтэлсэн тайландаа ОХУ-Украины нөхцөл байдал 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг 1 нэгж хувиар бууруулж, инфляцын түвшинг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж болзошгүй гэсэн тооцоолол гаргаад байна.

Зураг 25. ОХУ-Украины дайны дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, хувиар



Эх сурвалж: ЭЗХАХБ

Мөн томоохон эдийн засагтай улс орнууд инфляцыг бууруулах хүрээнд мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж байгаа нь хөгжиж буй орнуудаас хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлж болзошгүй юм. Цаашид ОХУ-Украины нөхцөл байдал хурцдаж геополитикийн тогтворгүй байдал удаан үргэлжлэх, Ковид-19 халдварын мутацид орсон шинэ хувилбарууд дахин тархах, инфляцын дарамт нэмэгдэх төлөв нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг хязгаарлах эрсдэл их байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс: Зэсийн үнэ 2022 оны эхний улиралд дунджаар 9,992 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 17.7 хувиар өссөн байна. Олон улсын шинжээчдийн таамаглаж байгаагаар зэсийн дундаж үнэ 2022 онд 9,870 ам.доллар, 2023 онд 9,720 ам.долларт орчимд хүрэхээр байна.

Алт: Алтны дундаж үнэ 2022 оны эхний улиралд 1,879 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 4.6 хувиар өссөн ба 2022 онд дунджаар 1,850 ам.доллар орчимд хүрэх төлөвтэй байна. Цаашид 2023-2025 онуудад 1,650-1,800 ам.доллар орчимд тогтворжихоор олон улсын шинжээчид дүгнэж байна. Алтны үнэ өсөж байгаа нь дэлхий нийтийг хамарсан улс төрийн тогтворгүй байдал, Ковид-19 цар тахал, АНУ болон Европын улс орнуудын эрчим хүчний асуудал, инфляцын өсөлт зэрэгтэй холбоотой байна.

Зураг 26. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн



Зураг 27. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/трой унц



Зураг 28. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн



Зураг 29. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/баррель



Эх сурвалж: Блүүмберг терминал

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн 2022 оны эхний улирлын дундаж үнэ 141 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 15.1 хувиар буурсан байна. БНХАУ цар тахлын дараах эдийн засгийг сэргээх чиглэлд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжин гангийн эрэлтийг нэмэгдүүлснээр төмрийн хүдрийн үнэ 2021 онд эрчимтэй өссөн бол уг төслүүд хэрэгжиж дууссанаар төмрийн эрэлт саарч, нөгөөтээгүүр Бразил, Австралийн төмрийн хүдрийн нийлүүлэлт нэмэгдэх төлөвтэй байгаа юм.

Шинжээчид төмрийн хүдрийн дундаж үнийг 2022 онд 116 ам.доллар, 2023 онд 89 ам.доллар орчимд байхаар тооцоолж байна.

Нүүрс: Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2022 оны эхний улиралд дунджаар 479 ам.долларт хүрч, 2021 оны дунджаас 2.2 дахин, өмнөх оны мөн үеэс даруй 3.8 дахин өсөөд байна. Нүүрсний үнийн өсөлт нь ОХУ-аас Украин улсад явуулж байгаа цэргийн ажиллагааны улмаас үүссэн эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдал, тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотой юм. Шинжээчид дэлхий нийтийн эдийн засгийн

сэргэлт, эрчим хүчний томоохон үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт өсөж, дунд хугацаанд нүүрсний үнэ тогтворжино гэж таамаглаж байна.

Газрын тос: Brent (Brent) газрын тосны 2022 оны эхний улирлын дундаж үнэ 95 ам.долларт хүрч өмнөх оны дунджаас 67.8 хувиар өслөө. Газрын тосны үнэ эргэн буурах хүлээлттэй байгаа ч ОХУ-Украины нөхцөл байдлаас хамааран газрын тосны зах зээлд тодорхойгүй байдал өндөр байна.

Эдийн засгийн 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт. Засгийн газар өнгөрсөн 2 жилд цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн эдийн засгийн уналтыг сааруулж, эдийн засгийг сэргээх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж ирсэн бол дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж урт хугацааны зорилтыг хангах сэргэлтийн бодлогуудыг авч хэрэгжүүлэхээр “Шинэ сэргэлт”-ийн бодлогыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Ковид-19 цар тахал, дэлхий дахины геополитикийн тогтворгүй байдал, үүнээс үүдэлтэй олон улсын зах зээлийн тодорхой бус байдал нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх төлөвтэй байгаа тул Засгийн газраас төсвийн хэмнэлтийн бодлого баримталж байна. Түүнчлэн, Монголбанкнаас төв банкны бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмж, 9% хувьд хүргэсэн нь зээлийн өсөлтийг бууруулах замаар салбаруудын өсөлтөд нөлөөлдөг учир энэ оны эдийн засгийн өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг бууруулан 2.6 хувь байхаар тооцооллоо.

2022 оны эхний улирлын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 3.5 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар буурсан байна. Энэхүү бууралтад нүүрс олборлолт 72.6 хувиар, газрын тосны олборлолт 95.3 хувиар тус тус буурч нийт уул, уурхайн салбарын үйлдвэрлэл 37.4 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин бүх төрлийн тээврээр энэ оны эхний улиралд 9.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 42.2 хувиар буурсан бол зорчигч тээвэр 2.1 дахин нэмэгдсэн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 2 сард 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.9 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 30. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Дотоод эдийн засгийн идэвхжил сул, макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсээд байгаа хэдий ч Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт татах, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийн үнийг тогтворжуулах зэрэг эдийн засгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, дунд хугацаанд цар тахлын өмнөх эдийн засгийн түвшиндээ хүрэх зорилтыг тавьж байна.

“Шинэ сэргэлт”-ийн бодлогыг хэрэгжүүлснээр дунд хугацаанд хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг арилгаж, томоохон төсөл хөтөлбөрүүдийг /Газрын тос боловсруулах үйлдвэр, Богдхан төмөр зам, Оюутолгойн далд уурхай зэрэг/ эрчимжүүлж барилга, бүтээн байгуулалтыг эхлүүлснээр цаашид эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2023 онд 5.0 хувиар, 2024 онд 5.1 хувиар өсгөж 2025 он гэхэд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6 орчим хувьд хүргэхээр зорьж байна.

Оюутолгойн далд уурхайн II үе шатны үйлдвэрлэл эхлэх болон Шинэ сэргэлтийн бодлогод туссан газрын тос боловсруулах үйлдвэр, авто болон төмөр зам, боомтын бүтээн байгуулалт, эрчим хүчний томоохон төслүүдийн бүтээн байгуулалт, барилга, угсралтын ажил эрчимтэй явагдаж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Шинжээчид олон улсын зах зээл дээрх уул уурхайн металлуудын үнийг дунд хугацаанд өндөр түвшинд хадгалагдана гэж төсөөлж байгаа нь манай экспортын гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.


Гадаад худалдаа. 2022 оны эхний улиралд нийт 126 улстай худалдаа хийсэн бөгөөд нийт худалдааны эргэлт 3.6 тэрбум ам. долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өссөн байна.

Импортын хэмжээ эхний улиралд өмнөх оны мөн үеэс 11 хувиар өсөж 1.7 тэрбум ам.долларт, экспортын хэмжээ 2.9 хувиар буурч 1.9 тэрбум ам.долларт хүрсэн байна. Экспортын бууралтад нүүрсний экспорт биет хэмжээгээр 62.7 хувиар, газрын тосны экспорт зогссон, төмрийн хүдрийн баяжмалын экспорт 67.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний улиралтай харьцуулахад 225.3 сая ам.доллараар буурч 251.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Цаашид, дэлхийн зах зээл дэх түүхий эд, эрдэс бүтээгдэхүүнүүдийн өндөр үнэ хэвээр хадгалагдаж, Засгийн газраас экспортыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд экспорт өсөж, экспортын хэмжээ 9.0 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд барилга, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын үйл ажиллагаа сэргэж, барилгын материал, үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийн импортыг нэмэгдүүлэх төлөвтэй байгаа хэдий ч Монголбанкнаас бодлогын хүүг өсгөсөн нь импортын өсөлтийг хязгаарлахаар байна. Импортын хэмжээ 2022 онд 7.7 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Зураг 31. Гадаад худалдаа, сая ам.доллар



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2022 онд 16.8 тэрбум ам долларт, гадаад худалдааны тэнцэл 1.2 орчим тэрбум ам.долларын ашигтай байхаар байна.

Гадаад худалдааны тэнцэл өмнөх оноос буурч, ханшийн дарамт өндөр байгаа нь гадаад валютын нөөцийн дарамтыг нэмэгдүүлж байгаа ч энэ онд алтны худалдан авалтыг нэмэгдүүлж, томоохон экспортлогч ААН-үүд валютын орох урсгалыг бий болгохоор хүлээгдэж байгаа нь төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахаар

байна. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2023-2025 онд дунджаар 0.9 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Засгийн газраас Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэн "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг батлан хэрэгжүүлж байна. Тус бодлогын нөлөөгөөр хилийн боомт орчмын дэд бүтэц сайжирч, экспортын хүчин чадал нэмэгдэхээр байгаа бол бүтээн байгуулалтын хөтөлбөрүүдийн нөлөөгөөр импортын хэмжээ өсөхөөр төсөөлж байна. Дунд хугацаанд барилгын материал, автобензин, дизель түлш, үйлдвэрлэлийн орц, машин, механизм, тэдгээрийн эд ангийн импорт өсөх төлөвтэй байна.

Төлбөрийн тэнцэл. 2022 оны 2 дугаар сарын байдлаар төлбөрийн тэнцэл 571 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 459 сая ам.доллаар нэмэгдэж 559 сая ам.долларт хүрсэн бол санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 34 сая ам.доллаар нэмэгдэж 110 сая ам.долларт хүрлээ.

Урсгал дансны алдагдал ийнхүү нэмэгдэхэд бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 125 сая ам.доллаар буурч, импорт 287 сая ам.доллаар өссөн нь голлон нөлөөллөө. Гадаад валютын улсын нөөц 2022 оны 3 дугаар сарын урьдчилсан дүнгээр 3,319 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон барааны импортын 5.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Зураг 32. Төлбөрийн тэнцэл, эхний 2 сарын байдлаар, сая ам.доллаар



Эх сурвалж: Монголбанк

Энэ онд гадаад худалдааны тэнцэл өмнөх оноос буурч, ханшийн дарамт өндөр байгаа нь гадаад валютын нөөцийн дарамтыг нэмэгдүүлж байгаа ч энэ онд алтны худалдан авалтыг нэмэгдүүлж, томоохон экспортлогч ААН-үүд валютын орох урсгалыг бий болгохоор хүлээгдэж байгаа нь төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулахаар байгаа бол ирэх онд Монголбанк, Хятадын Ардын Банкны хооронд байгуулсан 15 тэрбум юань буюу 6 их наяд төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл, Хөгжлийн банкны 30 тэрбум иен болон 500 сая ам.долларын

бондуудын төлбөрүүд төлөгдөхөөр хүлээгдэж байгаа нь төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийг бууруулахаар байна.

Инфляц. Инфляцын түвшин идэвхжиж 2022 оны 3 дугаар сарын байдлаар 14.4 хувьд хүрлээ. Жилийн инфляц 2022 оны сүүлийн хагаст саарах төлөвтэй байгаа хэдий ч оны эцэст 11.5 хувь хүрч, төв банкны зорилтоос өндөр байхаар байна. ОХУ-ын Украйнд хэрэгжүүлж буй цэргийн ажиллагаа нь манай улсын импортын шатахуун болон хүнсний барааны үнийг нэмэгдүүлж, инфляцын дарамтыг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээг 2022 онд үргэлжлүүлэхийн зэрэгцээ "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр хилийн саатлаас шалтгаалсан импортын бараа, түүхий эдийн үнийн өсөлт дунд хугацаанд тогтворжихоор байна.

Дунд хугацаанд томоохон бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдөж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд хүү багатай, хямд эх үүсвэртэй зээл олгохын зэрэгцээ, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр гадаад

худалдааны эргэлт нэмэгдэж, бараа нийлүүлэлт, татан авах үйл явц хялбар, шуурхай болж, бизнесийн зардал буурч нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт буурах төлөвтэй байна. Инфляцын түвшин дунд хугацаанд буюу 2023-2025 онд Монголбанкны зорилт орчимд байхаар хүлээгдэж байна.

1.7.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

Нэг. Хүний хөгжлийн бодлогын чиглэлээр:

Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд багшийн ур чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, суралцагчийн сургалтын ахиц дэвшлийн үнэлгээг хийж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулна.

- Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулна.
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлнэ.
- Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан 36 сургууль, 48 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна.
- Суралцагчид тав тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх хүрээнд 17 дотуур байрыг ашиглалтад оруулж, 19 спорт заалыг шинээр барих болон өргөтгөнө.
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол, эрүүл ахуйн стандартыг дээшлүүлж, "Үдийн хоол" хөтөлбөрт дунд ангийн 194.8 мянган сурагчдыг хамруулна.
- Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч, багш мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан тэтгэлэг олгоно.
- Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлнэ.
- Эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл байдлыг хангаж, уялдаа холбоог сайжруулна.
- Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Эрүүл чийрэг эр хүн", "Харшлаас сэргийлэх", "Элэг бүтэн Монгол", "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх", "Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ.
- Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчилнэ.

- Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих "Найрамдал-2" зуслангийн цогцолбор барина.
- Ахмад настан, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төвүүдийг байгуулна.
- Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэнэ.
- Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

Хоёр. Эдийн засгийн бодлогын чиглэлээр:

Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах мөнгөний бодлого хэрэгжүүлж, Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

- Санхүүгийн зах зээлийг өргөжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой санхүүжилт болон ногоон төслүүдийг дэмжих тогтолцоо бүрдүүлнэ.
- Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барьж, боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг холбоно.
- Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажил болон Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг тус тус үргэлжлүүлнэ.
- Арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн түүхий эдээ дотооддоо үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрүүд барина.

- Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулна.
- Хөдөө аж ахуйн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулна.
- Дотоодын мах, сүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэх хүрээнд сэрүүний улиралд нийлүүлэх түүхий сүүний хэмжээг 24.5 сая литрт хүргэж, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, фермийн тоог 9-өөр нэмэгдүүлж, нөөцөлж, борлуулах махны хэмжээг 15.0 мянган тонн-д хүргэнэ.
- Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын гоц халдварт өвчнийг бууруулна.
- Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 63.0 мянган га-д хүргэж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Газар тариалангийн үр ашгийг нэмэгдүүлж, үр тариа хадгалах элеватор байгуулна.
- Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх I, II төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, сурталчилгааг идэвхжүүлнэ.
- Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох цэгийг 100 км тутамд барьж байгуулна.

Гурав. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлогын чиглэлээр:

Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлж, төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг зогсоож, зөвлөн туслах эрх зүйн орчныг бүрдүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.

- Улсын хил хамгаалах салбарын байгууламжийн шинэтгэл хийж, техник технологийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулна.
- Дулааны цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад авна.

- Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хүрээнд барилга-инженерийн цэргийн ангийг шинээр байгуулж, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлнэ.

Дөрөв. Байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр:

Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглан хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хомсдол, доройтлыг бууруулж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 9.0 мянган га талбайг ойжуулж, ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх ажлыг 150.0 мянган га талбайд, ойн зохион байгуулалтын ажлыг 1,800.0 мянган га-д, ойн арчилгаа, цэвэрлэгээг 36.0 мянган га-д тус тус хийж гүйцэтгэнэ.

- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2.0 мянган га талбайг нөхөн сэргээнэ.
- Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах хүрээнд цөлжилтийг сааруулах талбайн хэмжээг 400.0 га-гаар нэмэгдүүлнэ.
- Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгааны ажлыг хийнэ.
- Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргана.
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, агаар дахь PM 2.5, PM 10 тоосонцрын агууламжийг бууруулна.
- Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Тав. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын чиглэлээр:

Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлнэ.

- Бага, дунд орлоготой 30.5 мянган иргэнийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна.
- Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.
- Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Хот доторх авто зам, явган хүний болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.


- Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

1.8.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Цар тахлын нөлөө. Дэлхийн зах зээлд уул, уурхайн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ өсөж, эрэлт нэмэгдсэн хэдий ч Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хилийн боомтуудад хүндрэл үүсэж, улмаар түүхий эдийн экспортын өсөлтийг огцом бууруулсан нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулж байна. 2021 онд дэлхийн эдийн засаг богино хугацаанд эргэн сэргээд байгаа ч бүс нутгийн эдийн засаг болон дэлхийн эдийн засгийн өсөлтийн ялгаатай байдлаас үүдэн идэвхжил сул хэвээр байгаа ба цар тахлын үргэлжлэх хугацаа, дэлхийн эдийн засагт үзүүлэх хор уршгийн хэмжээ тодорхойгүй, цаашид халдварын давлагаа дахин гарч болзошгүй эрсдэл хэвээр байна. Түүнчлэн, дэлхий дахинд үүсээд байгаа геополитикийн хурцадмал байдал манай улсын эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй байна. 2023 оны эдийн засгийн төсөөллийг цаашид олон улсын харилцааны нөхцөл байдал даамжрахгүй, хилийн хязгаарлалт алгуур суларна зэрэг таамаглалын хүрээнд боловсруулсан бөгөөд эдгээр таамаглалт нөхцөл бодит байдлаас зөрөх нь цаашдын төсөөлөл өөрчлөгдөх гол хүчин зүйл болохоор байна.

Улс орнуудын инфляц цаашид өсөх. Ихэнх улс орнуудын инфляц зорилтот түвшнээсээ давсан байна. Улс орнууд бодлогын хүүгээ өсгөж байгаа нь валютын урсгалыг хөгжиж буй орноос хөгжингүй орнууд руу чиглүүлж байна. Энэ нь хөгжиж буй орнуудын валют сулрах эрсдэлийг бий болгож байна.

Зураг 33. Улс орнуудын инфляц болон тэдгээрийн зорилтот түвшин, 2022.III сард



* Сүүлийн жилүүдийн хамгийн өндөр өсөлт
Эх сурвалж: Блүүмберг терминал

Инфляц цаашид эрчимжих дарамт хэвээр байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн сэргэлтийг дагасан эрэлтийн хүчин зүйлс, түүхий эд, хүнсний үнийн өсөлт болон дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний доголдол, тээврийн зардлын өсөлт зэрэг нь нөлөөлж байна. Тодруулбал:

1) 2022 оны 3 дугаар сарын байдлаар БНХАУ-д өдөрт шинээр бүртгэгдэх Ковид-19-ын тохиолдол 5,000 давж байна. Монголд Хятад Улсын COVID-ийг тэглэх бодлоготой холбоотой хил хязгаарлалт нь нийлүүлэлтийн хомсдолд нөлөөлж, импортын барааны үнийн дарамтыг бий болгож байна.

2) Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өссөн нь эрчим хүч, шатахуун, барилгын материалын үнийг өсгөж, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх шалтгаан болохоор байна. ОХУ Украйнд цэргийн ажиллагаа явуулсны /2022.02.24/ дараа эрчим хүч, хүнсний хангамжид нөлөөлж эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлөв. Орос, Украйн улс нь зарим түүхий эдийн гол экспортлогчид бөгөөд дайн, хориг арга хэмжээнээс үүдэлтэй тасалдал нь дэлхийн зах зээл дээр газрын тос, байгалийн хий, хүнсний үнэ өсөхөд хүргэж байна. Эдгээр нөлөөлөл нь инфляц удаан хадгалагдах нөхцөлийг бүрдүүлж, хүнс, эрчим хүч хэрэглээний импортын хувь ихтэй (Африкт 50 хүртэл хувь) бага орлоготой орнууд болон хөгжиж буй орнуудад хүндээр тусахаар байна.

3) 2020 онд Ковид-19-ын нөлөөгөөр улс орнуудын хүнсний бус инфляцын түвшин буурсан боловч хүнсний инфляц цар тахлын өмнөх үеэс өндөр байж, инфляцыг цаашид нэмэгдүүлэх нөлөөтэй байна. Энэхүү хүнсний үнийн өсөлт нь нийгмийн орлого багатай хэсэгт илүү хүндээр тусах эрсдэлтэй.

Тээвэр логистикийн хямрал. Дэлхийн худалдааны тэнцвэргүй байдал нь тээврийн зардлыг их хэмжээгээр нэмэгдэхэд хүргэж байна. Дэлхий нийтийн тээвэр, логистикийн түгжрэл, манай орны хилийн бүс дэх хязгаарлалтын улмаас гадаад худалдааны тээвэрлэлтийн хугацаа удааширч, тээврийн зардал дорвитой буухгүй байгаа нь инфляцыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа бөгөөд нөхцөл байдал хэзээ хэвийн горимд орох нь тодорхойгүй байна.

Тээврийн үнэ нэмэгдэж байгаа голлох шалтгаануудыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Улс орнууд хилээ хааж, зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь олон улсын тээврийн үйлчилгээ үзүүлдэг компаниудад тээвэрлэх барааны хомсдолыг үүсгэж байгаа ч зарим саруудад үйлдвэрлэл нэмэгдсэнээр бараа тээвэрлэх сул чингэлгийн хомсдолыг бий болгож байна.


Далайн тээврийг орлох өөр хямд өртөгтэй тээврийн хувилбар байхгүй тул одоо үүсээд буй тээврийн зардлын өсөлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байна. Хэдийгээр агаарын тээврийн хэрэгсэл болон галт тэргийг ашиглаж болох ч тээж чадах ачааны хэмжээ нь харьцангуй хязгаарлагдмал бөгөөд цар тахлын үед эдгээр тээврийн зардал мөн адил өсөөд байна.

Улс орнуудын эдийн засаг харилцан адилгүй сэргэж байна. Зарим улс орнуудын экспортын хэмжээ цар тахлын өмнөх үеийг давсан байхад зарим улс оронд бүрэн сэргээгүй байна. Энэхүү тэнцвэргүй өсөлтөөс шалтгаалж ойрын саруудад ачаагүй чингэлгийн тээвэрлэлтийн хүндрэлтэй асуудлууд үргэлжлэхээр байгаа нь тээврийн зардлыг нэмэгдэхэд нөлөөлж байна.

Төлөвлөсөн далайн тээвэр цуцлагдах эсвэл хойшлогдсоноос шалтгаалж далайн боомтуудад ихээхэн бөөгнөрөл үүсээд байна. Хэдийгээр энэ оны 4 дүгээр сараас хойш төлөвлөсөн цагтаа очиж байгаа далайн тээврийн тоо эхний улирлаас нэмэгдэж байгаа ч сүүлийн 10 жилийн хамгийн доод түвшинд хэвээр байна. Энгийн үед нийт онгоцны 70-80 хувь нь төлөвлөсөн цагтаа очдог байсан бол одоогоор энэ үзүүлэлт 40 гаруй хувьтай байна.

2021 оны 3 дугаар сард дэлхийн худалдааны 12 орчим хувь дайран өнгөрдөг Ази-Европыг холбосон хамгийн дөт далайн зам болох Суэцийн сувагт Evergreen компанийн онгоц 6 хоногийн турш гацсан нь тээвэр удаашрахад нөлөөлжээ.

Зураг 34. Дэлхийн чингэлэг тээврийн үнийн индекс, 2020 оны 5-р сар = 100



Эх сурвалж: Дэлхийн чингэлэг тээврийн индекс ба судлаачийн тооцоолол

Ковид-19-ын цар тахлын дэлхийн худалдаанд үзүүлэх нөлөөлөл нь дараах хоёр онцлогтой байна. Нэгдүгээрт, цар тахал нь бараанаас илүүтэйгээр үйлчилгээний худалдааны эргэлтэд нөлөөлсөн. Үйлчилгээний худалдааны эргэлт 2020 онд 20 гаруй

хувиар буурсан нь барааны худалдааны бууралтаас даруй дөрөв дахин өндөр байна. Хоёрдугаарт, цар тахлын худалдаанд үзүүлэх нөлөөлөл нь улс орнуудад харилцан ялгаатай байна. Тухайлбал, БНХАУ-ын худалдааны бууралт бусад улс орнуудтай харьцуулахад бага байгаа нь тус улсын бараа бүтээгдэхүүний эрэлт өндөр, цар тахлыг богино хугацаанд хумьж, эдийн засгаа нээж чадсантай холбоотой.

Дэлхий нийтийн тээвэр, логистикийн түгжрэл, манай орны хилийн бүс хязгаарлалтын улмаас гадаад худалдааны тээвэрлэлтийн хугацаа удааширч, тээврийн зардал өсөж байгаа нь инфляцыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа бөгөөд нөхцөл байдал хэзээ хэвийн горимд орох нь тодорхойгүй байна.

БНХАУ-ын хилийн хориг. 2022 оны 3 дугаар сарын байдлаар БНХАУ-д өдөрт шинээр бүртгэгдэх Ковид-19-ын тохиолдол 5,000 давж байна. Халдварын тархалт Хонг Конг, Макао, Тайвань болон бусад олон мужуудад эрчимжиж байгаагаас 45 сая гаруй хүн хөл хорионд ороод байна. “Sinovac” компанийн хөгжүүлсэн Ковид-19 халдварын эсрэг вакцин “Омикрон” хувилбарын эсрэг үр нөлөө багатай гэсэн судалгаа гарсан бөгөөд барууны орнууд БНХАУ-ыг барууны вакцин хэрэглэхийг зөвлөж байна. БНХАУ-ын Засгийн газар цар тахлын эсрэг “Тэг тохиолдол” буюу хатуу арга хэмжээгээ үргэлжлүүлэхээр байна. Улмаар хилийн хориг урт хугацаанд үргэлжлэх магадлалтай байгаа нь манай эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Дэлхий нийтийг хамарсан тогтворгүй байдал. Монгол Улсын эдийн засаг төрөлжилт багатай, далайд гарцгүйн улмаас эдийн засгийн өсөлт нь дэлхийн зах зээл дээрх түүхий эд, хоёр хөршийн эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг. Тиймээс дэлхийн зах зээлд шууд нөлөөлөхүйц томоохон үйл явдлууд Монгол Улсын эдийн засагт шууд бусаар нөлөөлнө. Жишээлбэл, Ковид-19-ын шинэ хувилбар дэгдэх, дархлаажуулалт хэт удаашрах; дэлхийн дулаарлаас үүдэн улс орнууд нүүрсний эрэлтээ бууруулах; түүхий эдийн супер циклд өртөх; БНХАУ, Энэтхэг улсын стратегийн нөөцийн хэрэглээ өөрчлөгдөх; Ираны асуудал (цөмийн хөтөлбөр, хориг, экспортын сэргэлт); ОХУ, Украйны дайн болон үүнээс үүдэн дэлхийн зах зээлд үзүүлэх нөлөө гэх мэт.

Дээрх хүчин зүйлээс ОХУ-ын Украин улсад хэрэгжүүлж буй цэргийн ажиллагаанаас шалтгаалан газрын тос болон хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол үүсэж, үнэ өсөх эрсдэл үүсээд байна. Дэлхийн олон улс орнууд ОХУ-ын худалдааны болон санхүүгийн зах зээлд хориг тавьснаас үүдэн ОХУ импортолж буй бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэх болсон. Үүнээс үүдэн шатахууны үнэ нэмэгдэж, улмаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөж, инфляц нэмэгдэх дарамт өсөж байна.

Түүнчлэн, дэлхий дахинд үүсээд байгаа геополитикийн хурцадмал байдал нь улс орнуудын эдийн засгийн өсөлтөд харилцан адилгүй нөлөөлөхөөр байгаа нь эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт төсөөлснөөс буурах. Дэлхий нийтэд үүсээд буй улс төрийн тогтворгүй байдал, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын тодорхойгүй байдлын улмаас уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэ дунд хугацаанд өндөр хэвээр хадгалагдах хүлээлтийг бий болгоод байна. Гэвч Ковид-19-ын цар тахлын тархалт, БНХАУ-аас баримтлах бодлого, манай улсын хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт зэрэг нь экспортын орлогод (зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ болон биет хэмжээ) нөлөөлөхийг анхаарах шаардлагатай юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, үнэ өсөх. Хур тунадасны хэмжээ 2022 онд олон жилийн дунджаас бага байх, хаваржилт хүндрэх тохиолдолд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, бүтээмж төсөөлсөн хэмжээнээс бага байх эрсдэлтэй байна. Мөн 2021 онд малын зүй бус хорогдол өндөр, малын гоц халдварт өвчний тархалт ихтэй байсан нь 2022 оны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, хүнсний бүлгийн үнийг өсгөх эрсдэл үүсгэж болзошгүй байна.